

Эм найруулагчийн мэргэжлээр эм барих зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил

Хувилбар 1

Сорил хариулах заавар

1.Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.

2.Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)

1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)

2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)

Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)

Бүх хариулт зөв бол (E.)

3.Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

Зөв, Зөв, Зөв (А.)

Зөв, Зөв, Буруу (В.)

Зөв, Буруу, Буруу (С.)

Буруу, Зөв, Буруу (D.)

Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Эмнэлгийн эмийн сан нь эмнэлгийн тасаг кабинетэд эм олгох үндэс нь юу вэ?

A. Нэхэмжлэх

B. Итгэмжлэх

C. Захиалга

D. Тодорхойлолт

E. Падаан

/2./ Хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах замаар хүн амын эрүүл мэндийг хангахад чиглэсэн анагаах ухаан, нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээ нь

A. Эмнэлгийн тусламж үйлчилгээ

B. Эрүүд мэндийн байгууллага

C. Эрүүл мэндийг хамгаалах

D. Эрүүл мэндийг дэмжих

E. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ юм

/3./ Эмийн санд этилийн спиртийг яаж хадгалах вэ?

A. Төмөр саванд давхар хийнэ

B. Хүрэн өнгийн шилэнд хийж харанхуй газар

C. 20 С0

D. Шилэн бөглөөтэй саванд хийж сэрүүн газар хадгална

E. Харанхуй газар хадгална

/4./ Нэг удаагийн жоронд цэвэр спиртийг хэдий хэмжээтэй олгож болох вэ?

A. 30 мл

B. 50 мл

C. 70 мл

D. 100 мл

E. 20мл

/5./ Алдаатай бичигдсэн жорын бүртгэлийг хэн бүртгэдэг вэ?

A. Эм найруулагч

B. Эм шалгагч

C. Жор баригч

D. Эм шинжлэгч

E. Эмийн сангийн эрхлэгч

/6./ Эм найруулагчийн ажлын ширээний өндөр хөдөлмөр зохион байгуулалт ёсоор хэд байх ёстой вэ?

A. Хэмжээ харгалзахгүй

B. 75-90 см

C. 65-95 см

D. 60-60 см

E. 75-100 см

/7./ Эмийн гадаад байдал, өнгө, үнэр, амт 1 төрлийн эсэх, механик хольц зэргийг шалгах нь эмийн сангийн ямар шалгалтанд хамаарах вэ?

A. Бичгийн шалгалт

- B. Мэдрэхүйн шалгалт
- C. Асуух
- D. Химийн
- E. Физикийн

/8./ Тарилгын эмийг бэлтгэснээс хойш хэдий хугацаанд ариутгах ёстой вэ?

- A. 1 цаг 30 мин хэтрэхгүй
- B. 1 цагаас хэтрэхгүй
- C. 2 цагаас хэтрэхгүй
- D. 3 цагаас хэтрэхгүй
- E. Хугацаа хамаарахгүй

/9./ Эм найруулах дахин савлах технологийн үйл ажиллагааны явцад эмийн хими, физикийн шинж чанараас хамаарч уурших, дэгдэх, бургих, савласан сав баглаа боодлын хананд наалдах, талст усаа алдах зэргээр үндсэн хэмжээнд өөрчлөлт гарахыг

- A. Эмийн хорогдол
- B. Эмийн нормчлогдсон хорогдол
- C. Эмийн хэвийн хорогдол
- D. Эмийн алдагдал гэнэ
- E. Эмийн зүй бус хорогдол гэнэ.

/10./ Эмийн агуулахад байгаа эм барааны өрөлт, төрөлжилт, хураалтыг жигдрүүлж байх эрхтэй хүнийг сонго.

- A. Дефектар
- B. Карт хөтлөгч
- C. Шалгагч
- D. Туслах ажилтан
- E. Эмийн сангийн эрхлэгч

/11./ Бюреткийн системийг хэрхэн цэвэрлэх вэ?

- A. Сард 3 удаа 5% гичийн уусмалаар угааж нэрмэл усаар зайлна
- B. 7 хоногт 1 удаа 5% гичийн уусмалаар угааж нэрмэл усаар зайлна
- C. 7 хоногт 1 удаа 5% гичийн уусмалаар угааж халуун усаар зайлна.
- D. Сард 2 удаа 5% гичийн уусмалаар угааж усаар зайлна
- E. Өдөр болгон 5% гичийн уусмалаар угааж халуун усаар зайлна.

/12./ Эмийн жоронд эмийн бэлдмэлийн нэрийг ямар нэрээр бичих вэ?

- A. Олон улсын нэршил
- B. Үйлчлэгч бодисын нэрээр
- C. Патентын бус худалдааны нэрээр
- D. Химийн нэрээр
- E. ФК-н нэршил

/13./ Эмийн сангийн жор баригч гэнэт солигдох эсвэл ээлжийн амралтаа авах тохиолдолд ямар тооллого хийгдэх вэ?

- A. Шалгалтын
- B. Төлөвлөгөөт
- C. Хяналтын
- D. Ээлжийн
- E. Гэнэтийн

/14./ Шинжилгээний зориулалтаар эм биобэлдмэлээс дээж авах эрх хэнд байх вэ?

- A. Эрүүл мэндийн яамны ажилтан
- B. МЭИК-ны дарга
- C. УМХА-ны байцаагч
- D. Хүний эмийн салбар зөвлөлийн гишүүд
- E. Эмийн сангийн эрхлэгч

/15./ Эм бүртгэх асуудлыг хаана шийдвэрлэх вэ?

- A. ЭМУХА
- B. ЭМЯ
- C. МЭИК
- D. Улсын гаалийн газар
- E. Анагаах ухааны үндэсний хүрээлэн

/16./ Эмийн сангийн эм барааны нөөц нь ямар хөрөнгөнд хамаарах вэ?

- A. Эргэлтийн бус
- B. Үндсэн
- C. Нормчлогдоогүй
- D. Эргэлтийн

Е. Нормчлогдох

/17./ Эмчийн бичсэн энгийн эмийн жор бичсэнээс хойш хэд хоногийн хүчинтэй байх вэ?

- A. 3 хоног
- B. 7 хоног
- C. 15 хоног
- D. 21 хоног
- E. 1 сар

/18./ Эм найруулах өрөөний чийглэг, дулаан, агаарын хөдөлгөөний хурд хэд байх вэ?

- A. Чийглэг 30-60 % дулаан 16-18 C0, хурд 0.3м\С
- B. Чийглэг 20-50 % дулаан 18-20 C0, хурд 0.1 м\С
- C. Чийглэг 30-50%, дулаан 18-20 C0, хурд 0.2м\С
- D. Чийглэг 25-35%, дулаан 18-20 C0, хурд 0.2 м\С
- E. Чийглэг 35-50%, дулаан 18-22 C0, хурд 0.1 м\С

/19./ Эмийн сангаас явуулах эмийн мэдээллийг хэрхэн ангилж болох вэ?

- A. Эмч, хөдөлмөрчид
- B. Эмч, эм зүйч, хэрэглэгч
- C. Эмч, эм зүйч
- D. Эмч нарт
- E. Хөдөрлмөрчид,эмч нарт

/20./ Эм найруулагч А бүртгэлийн эмийг хэнээр хэмжүүлж авч эмээ найруулах вэ?

- A. Эмийн сангийн эрхлэгч
- B. Жор баригч
- C. Шалгагч
- D. Шинжлэгч
- E. Эм найруулагч өөрөө хэмжинэ

/21./ Эмийн зохисгүй хэрэглээнд нөлөөлөх хүчин зүйлүүдийг сонго.

- 1. Эм хангамжийн систем
- 2. Эм олгогч
- 3. Жор бичигч
- 4. Эмийн сан
- 5. Хүн ам

/22./ Эмийн сангийн салбарт хөтлөгдөх анхан шатны бүртгэлийг сонгоно уу.

- 1. Нэрмэл усны шинжилгээний бүртгэл
- 2. Жорын бүртгэл
- 3. Найруулсан эмийн бүртгэл
- 4. Эмийн сангийн орлого, зарлагын бүртгэл
- 5. Мансууруурах, сэтгэц нөлөөт эмийн бүртгэл

/23./ Эмийн сангийн зорилгод дараах зүйлийг авч үзэж болно.

- 1. Хэрэглэгчдийн эм авах хүлээгдлийн цагийг багасгах*
- 2. Эмийн зах зээлийг судлах
- 3. Үйлчилгээний төрөл бүрийн хэлбэрүүдийг бий болгох
- 4. Эмийн үнийг бууруулах
- 5. Цалин нэмэх

/24./ Монгол улсын эмийн улсын бүртгэлийн дүрэмд дараах зүйлс хамаарагдахгүй.

- 1. Радио идэвхт бодис
- 2. Төрөл бүрийн эликсир
- 3. Гоо сайхны бэлдмэл
- 4. Монгол улсын эмчилгээ,урьдчилан сэргийлэх практикт урьд өмнө хэрэглэж байгаагүй зүйлс
- 5. Шинэ эм

/25./ Гэрлээс хамгаалж хадгалах бодисуудад аль нь орох вэ?

- 1. Аскорбины хүчил
- 2. Димедрол
- 3. Глютамины хүчил
- 4. Спирт
- 5. Анальгин

/26./ Тарилгын эмүүдийг ямар нөхцөлд хадгалах вэ?

- 1. Сэрүүн нөхцөлд
- 2. Гэрлээс хамгаалсан нөхцөлд
- 3. Эвдэрч гэмтэхээс хамгаалсан
- 4. Хуурай нөхцөлд
- 5. Бусад эмийн бодисоос тусад нь

/27./ Эм зүйн тусламжинд дараах үндсэн шаардлагууд тавигдана.

1. Эм зүйн нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх
 2. Тусламжийг хэрэгцээтэй тухайн цаг хугацаанд нь үзүүлэх
 3. Үйлчилгээг хүссэн хэмжээнд нь хүртээмжтэй
 4. Сургалтанд сууж мэдээлэл өгөх
 5. Анхны тусламж үзүүлэх
- /28./ Даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох эмийн жор бичих талаар зөв хариултыг сонгоно уу.
1. Эмийн жорыг стандартын дагуу өрхийн эмч бичнэ.
 2. Даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох эмийг бусад эмтэй нэг жорын маягт дээр бичихийг хориглоно
 3. Жор нь бичигдсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хүчинтэй
 4. Нэг жорын маягт дээр хэдэн ч жор бичиж болно.
 5. Жорыг ямар ч хэлээр бичиж болно.
- /29./ Шингэн эмүүдийг яаж хадгалах вэ?
1. Хуурай нөхцөлд
 2. Сэрүүн нөхцөлд
 3. Бусад эмийн бодисоос тусад нь
 4. Гэрлээс хамгаалсан нөхцөлд
 5. Үйлдвэрийн сав баглаанд
- /30./ Үйлчлүүлэгсэд, өвчтөнд өгөх эмийн мэдээллийг сонгоно уу.
1. Өөрийгөө дур мэдэн эмчлэхийн хор холбогдол
 2. Эмийг хэрэглэж байгаа үед гарч болох хариу урвал
 3. Эмийг гэрийн нөхцөлд хэрхэн хадгалах
 4. Эмийн чанарыг шалгах арга
 5. Эмийн үнэ
- /31./ Эмийн сангийн бүтэц үйл ажиллагаа стандартад зааснаар эмийн сангийн дотоод бэлдмэлийн нөөц хэд хоногийн хугацаатай байх вэ?
1. 5 хоногоос илүүгүй
 2. Хугацаа хамаагүй
 3. 1 сар
 4. Гурав хоногоос илүүгүй
 5. 10-15 хоногийн нөөцтэй.
- /32./ Эрүүл мэндийн тухай хуулийн “эмчлэх” гэсэн нэр томъёог зөв онооно уу.
1. Өвчнийг оношлох, эмчлэх хойшлуулшгүй үйл ажиллагаа
 2. Хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг зохион байгуулах цогц арга хэмжээ
 3. Хүн амд эрүүл мэндийн зайлшгүй болон эмнэлгийн анхны тусламж үзүүлэх үйл ажиллагаа
 4. Өвчнийг оношлох, илааршуулах, өвчтөнийг сэргээн засах, өвчнөөс сэргийлэхэд чиглэгдсэн эмчийн мэргэжлийн цогц үйл ажиллагаа
 5. Өвчтөнийг сэргээн засах, өвчнөөс сэргийлэхэд чиглэгдсэн цогц үйл ажиллагаа
- /33./ Температурын нөлөөнөөс хамгаалж хадгалах бодис аль нь вэ?
1. Эфирийн тос
 2. Спирт
 3. Вакцин сийвэн
 4. Тосон түрхэцүүд
 5. Тосон суурьтай лаанууд
- /34./ Эмийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудыг нэрлэнэ үү.
1. Алтанбулаг
 2. Буянт-Ухаа
 3. Замын –Үүд
 4. Эрээнцав
 5. Гашуун сухайт
- /35./ Мансууруулах сэтгэцэт нөлөөт эмээр үйлчлэх зөвшөөрөл бүхий эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангийн үйл ажиллагаанд юуг хориглох вэ ?
1. Захиалгын дагуу өөр эмийн санд олгох
 2. Өөр мансууруулах болон сэтгэц нөлөөт эмээр солилцох
 3. Нэг удаагийн тунгаас дээш хэмжээгээр олгох
 4. Эмчилгээний үйлдэл нь төсөөтэй өөр эмээр орлуулан өгөх
 5. Мансууруулах сэтгэц нөлөөт эмийг жоргүйгээр олгох
- /36./ Дараах эмүүдээс Монгол улсын практикт хэрэглэхийг зөвшөөрсөн мансууруулах эмийг сонгоно уу / ЭМС-ын 2003 оны 306 тоот тушаал /
1. Кодейн
 2. Морфин

3. Бупренорфин
4. Фентанил
5. Омнопон

/37./ Эм бараа материал үнэт зүйлсийн хөдөлгөөн нь дараах зүйлсээс бүрдэнэ.

1. Ашиг
2. Орлого
3. Тогтмол зардал
4. Зарлага
5. Гүйлгээ

/38./ Мөнгөний нитратыг нягт таглаатай хүрэн шилэнд хийж, гадуур нь хар цаасаар ороожээ. Ямар шинж чанартай учраас ингэж хадгалж байна вэ?

1. Дэгдэмхий бодис
2. Чийгнээс хамгаалж хадгалах бодис
3. Температурын нөлөөнөөс хамгаалж хадгалах бодис
4. Гэрлийн нөлөөгөөр урвалд ордог бодис
5. Сэрүүн газар хадгалах бодис

/39./ Бараа материалын тайланд анхан шатны баримтуудыг цаг хугацааны дарааллын дагуу бичихдээ ямар зарчим баримтлах вэ?

1. Орлого бичигдсэн дарааллаар
2. Тооллогын бүртгэлд бичигдсэн дараалаар
3. Гүйлгээ явагдсан хугацааны дарааллаар
4. Баримт бичигдсэн хугацааны дарааллаар*
5. Зарлага бичигдсэн дарааллаар

/40./ Эмийн сангийн борлуулалтанд нөлөөлөх гол хүчин зүйлүүд юу вэ?

1. Эм барааны хугацаа
2. Эм барааны нөөц
3. Эм барааны татан авалт
4. Эм барааны нэр төрөл
5. Эм барааны чанарын баталгаажилт

/41./ Эм найруулагч нь байнга олонтаа давтагддаг штангластай эмийг ойрхон байрлуулна. Байрлуулахдаа эмтэй штангласуудыг аль болох нэг байранд байнга байлгах зарчмыг баримтлана.

/42./ Мансууруулах эмийн жорын маягт нь стандартын дагуу батлагдсан хэмжээтэй шаардагдах мэдээллийг агуулсан байна. Үүний тулд эмийн жорын хэвлэмэл маягтыг индексжүүлэн тэмдэг дарж баталгаажуулна.

/43./ Эмнэлгийн эмийн санд тарилгын шингэн бэлтгэж болно. Учир нь эмнэлгийн бүх эмийн сангуудад үүнийг зөвшөөрдөг.

/44./ Эмийн санд эм шинжлэгчийн ширээг заавал ажилуулах шаардлагагүй. Учир нь эмийн бүтээгдхүүний чанарын баталгаажуулалт нь GMP-ийн шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэгдсэнээр хангагдана.

/45./ Эмийн үндэсний зөвлөл нь эмийн үндэсний бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй орон тооны мэргэжлийн зөвлөх байгууллага. Иймд зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтанд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.

/46./ Түргэн гэмтэлд орж чанар байдал нь өөрчлөгддөг ийлдэс, оношлуурыг тээвэрлэхэд тээврийн ямар хэрэгсэлийг сонгох вэ ?

- A. Автомашин
- B. Төмөр зам
- C. Усан замын тээвэр
- D. Агаарын тээвэр
- E. Аль нь ч болно.

/47./ Ашиглах болон устгах явцад хүрээлэн буй орчинд хортой нөлөө үзүүлэхгүй байх нь сав боодлын аюулгүй байдлын алинд нь хамаарах вэ ?

- A. Экологт нөлөөлөх байдал
- B. Найдвартай байдал
- C. Нийцэлтэй байдал
- D. Харилцан орлуулж солих боломж
- E. Чанартай байдал

/48./ Эмийн гадаад худалдааны гэрээ байгуулах үед тусгагдаагүй улс төрийн хямрал,эдийн засгийн хориг байгалийн гамшиг гарсанаас болж эмээ авч чадахаа болих нөхцөлийг ямар нөхцөл гэж нэрлэх вэ?

- A. Арбитрын
- B. Урьдчилсан
- C. Форсмажорын
- D. Гэрээнд заагдаагүй
- E. Гэрээний дараах

/49./ Барааг ижилсгэх буюу түүний тусгай шинж чанар, барааг бэлтгэгч, барааны чанарын ба тооны тодорхойлолтын тухай хэрэглэгчдэд мэдээллийг өгөхөд зориулагдсан, бараа савлагаан дээр тэмдэглэсэн текст буюу зураг бүхий барааны мэдээллийн хэрэгсэлийг юу гэж нэрлэх вэ ?

- A. Барааны тэмдэг
- B. Код
- C. Тохирлын тэмдэг
- D. Хаяглалт
- E. Цуврал

/50./ Хэлэлцэгч талуудын хооронд ямар нэгэн харилцаа тогтоох ба уг харилцааг зохицуулах тухай хэлэлцэн тохиролцсон баримт бичиг нь

- A. Мэдээ
- B. Тодорхойлолт
- C. Илтгэл
- D. Гэрээ
- E. Албан бичиг юм.

/51./ Эмийн эргэлтийн сан нь мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн тайланг хаана гаргаж өгөх вэ ?

- A. Нийслэлийн эрүүл мэндийн газар
- B. Аймгийн эрүүл мэндийн газар
- C. ЭМЯ
- D. Эм эмнэлгийн хэрэгсэлийн хэлтэс
- E. Нийгмийн даатгалын газар

/52./ Тодорхой таваарыг үйлдвэрлэх болон үйлчилгээ явуулахад зайлшгүй шаардлагатай материалын нөөцөөр түншүүд түүний өрсөлдөгчийг хангагч ажил төрлийн байгууллага хүмүүсийг юу гэх вэ ?

- A. Нийлүүлэгч
- B. Зуучлагчид
- C. Харилцагчид
- D. Өрсөлдөгчид
- E. Түншүүд

/53./ Агуулахаас эмийн сан, эмнэлгийн байгууллагуудад барааг олгох үндэслэл нь

- A. Зарлагын падаан
- B. Хүсэлт
- C. Эмийн захиалга
- D. Эмийн орлого
- E. Дагалдах баримт

/54./ Өрсөлдөгчийн бараа үйлчилгээг ялгаатай болгож нэг худалдагч буюу нэг хэсэг худалдагчдын бараа үйлчилгээг ижилсэхэд зориулагдсан нэр, нэр томьёо, тэмдэг, зураг буюу тэдгээрийн хослол нь

- A. Барааны таних тэмдэг
- B. Барааны сав боодол
- C. Барааны тэмдэг
- D. Барааны нэр төрөл
- E. Барааны хослол

/55./ Эмийн баглаа боодол, өнгө, хэлбэр, үнэ, эм үйлдвэрлэгчдийн барааны тэмдэг, тэдний үйлчилгээ гэх мэт бодитой мэдрэгддэг, мэдрэгддэггүй шинж чанаруудын нийлбэр цогцыг

- A. Эмийн бодлого
- B. Эмийн чанар
- C. Чанарын баталгаажилт
- D. Эмийн тодорхойлолт
- E. Эмийн бүтээгдхүүн гэнэ

/56./ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зориулан хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар ирсэн эм, эмнэлгийн хэрэгсэлийн мэдээний нэгдсэн сантай байна.

- A. Монгол Эм импекс концерн
- B. Эрүүл мэндийн улсын хяналтын алба
- C. Эрүүл Мэндийн Яам

- D. Эрүүл мэндийн газар
E. Гаалийн ерөнхий газар
- /57./ Зах зээлийг худалдан авагчдын тодорхой бүлэгт хуваах үйл ажиллагааг юу гэж нэрлэх вэ ?
- A. Зах зээлийг шилж сонгох
B. Зах зээлийг сегментчилэх
C. Барааны нэр төрөл бүрдүүлэх
D. Сегментийг шилж сонгох
E. Зорилтот сегмент
- /58./ Тухайн барааны хэрэглээний чанарын нийлбэр цогцыг юу гэж нэрлэх вэ ?
- A. Барааны хэрэглээний үнэ цэнэ
B. Барааны чанар
C. Барааны өрсөлдөх чанар
D. Барааны бодлого
E. Барааны мөчлөг
- /59./ Эрх бүхий албан тушаалтнаас Монгол улсын хууль тогтоомжийн үндсэн дээр тэдгээрийг биелүүлэхийн тулд тухайн байгууллагын эрх хэмжээнд гаргадаг эрх зүйн баримт бичиг нь ямар баримт бичиг вэ?
- A. Дүрэм
B. Тушаал
C. Заавар
D. Захирамж
E. Тогтоол
- /60./ Зорчигчийн хувийн хэрэглээний яаралтай тусламжийн эмийг хэдэн хоногийн нөөцтэйгээр авч явахыг зөвшөөрөх вэ ?
- A. 14 хоног
B. 1 сар
C. 21 хоног
D. 7 хоног
E. 10 хоног
- /61./ Олон улсын зах зээлд гарахын тулд ямар шийдвэрүүдийг гаргах шаардлагатай вэ?
1. Олон улсын зах зээлийн орчинг судлах
2. Гадаад зах зээлд гарах нь зорилгод тохирох эсэх
3. Ямар зах зээлд гарах тухай шийдвэр гаргах
4. Маркетингийн иж бүрдлийн бүтцийн тухай шийдвэр гаргах
5. Ямар аргаар зах зээлд гарах тухай шийдвэр гаргах
- /62./ Дотоод гадаадын зах зээлээс эм сонгож авах шалгууруудыг сонго.
1. Үйлчлэлийн идэвх сайтай
2. Эмнэлгийн тусламжийн янз бүрийн түвшинд хэрэглэж болох
3. Олон өвчинд хэрэглэх
4. Боломжийн үнэ өртөгтэй
5. Гаж нөлөө багатай
- /63./ Зорчигчийн хувийн хэрэглээнд зориулан дараах төрлийн эмийг авч явахыг хориглоно.
1. Судсаар сэлбэх шингэн
2. Антибиотик тариа
3. Мансууруулах эм
4. Цусны бэлдмэл
5. Антибиотик уух
- /64./ Эмийн зах зээлийн сонголтонд зайлшгүй авч үзэх асуудлуудыг сонгоно уу.
1. Эмийн сангийн байршил
2. Эмийн үнэ
3. Эмийн зах зээлийн багтаамж
4. Барааны үйлдвэрлэлийн хэмжээ
5. Барааг бүтээх технологи
- /65./ Эмийн талаар зар сурталчилгаа явуулахад дараах дэгийг баримтлана.
1. Зах зээлийн тодорхой сегмент рүү чиглэсэн байна
2. Рекламны текст нь 50-60 хуудаснаас хэтрэхгүй байна
3. Плакатан дээрх үг нь 20-оос хэтрэхгүй байх
4. Реклам нь тайван анхаарал татахуйцаар байх
5. Зурагтын реклам нь 5 мин байх ёстой.
- /66./ Маркетингийн нийгэм, ёс зүйн үзэл баримтлалын зарчмуудыг сонгоно уу.
1. Хэрэглэгчдийн хэрэгцээтэй шинэ эмийн бэлдмэлийг бий болгох
2. Аюулгүй гаж нөлөө багатай эмээр үйлчлэх

3. Эмийн үнийн оновчтой бодлого барих
 4. Стандартын шаардлага хангасан түүхий эд, туслах материалыг ашиглах
 5. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх үйл ажиллагааг үр дүнтэй явуулах эм зүйн тусламж, боломжоор хангах
- /67./ Эмийн зах зээлийг сонгоход дараах асуудлуудыг анхаарах нь зүйтэй.
1. Худалдан авагчдын сэтгэл зүйн онцлог
 2. Эрэлт хэрэгцээнд гарч болох өөрчлөлт
 3. Худалдаа хийх аргын хэрэглэгчдэд үзүүлэх нөлөө
 4. Нэмүү өртгийг нэмэгдүүлэх боломж
 5. Импортоор авах эмийн хэмжээг нэмэгдүүлэх
- /68./ Маркетингийн үндсэн ухагдхуунуудыг сонгоно уу.
1. Гачигдал ба шалтгаан
 2. Хэрэгцээ
 3. Эрэлт
 4. Таваар
 5. Зах зээл
- /69./ Эмийн сав боодол нь дараах зорилгоор бүтээгдэнэ.
1. Барааг эвдэрч гэмтэхээс хамгаалах
 2. Барааг тээвэрлэхэд оновчтой болгох
 3. Бүтээгдхүүнийг мэдээлэх
 4. Борлуулалтыг эрчимжүүлэх
 5. Үнэ нэмэх
- /70./ Хамт олон-эрүүл мэнд төсөл буюу Бамакогийн санаачлагын гол агуулгыг сонгоно уу.
1. Хамт олны оролцоо хүч анхаарлыг эрүүл мэндэд анхаардаг болгох
 2. Хувь хүн хамт олныг өөрөө өөрсдийнхөө эрүүл мэндэд анхаардаг болгох
 3. Орон нутагтаа тулгарч буй асуудал бэрхшээлийг хамтаараа шийдвэрлэх
 4. Хамт олноороо идэвхи гарган ажиллавал асуудлыг орон нутагтаа шийдвэрлэж болох юм байна гэсэн үнэмшлийг төрүүлэх
 5. Эмнэлгийн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх
- /71./ Зайлшгүй шаардлагатай эмийг ач холбогдлоор нь шинжлэх аргуудыг сонгоно уу.
1. Богино хугацаатай эмийн
 2. ABC үнийн
 3. Өргөн хэрэглээний эмийн
 4. VEN шинжилгээний
 5. Удаан хугацаанд хэрэглэх эмийн
- /72./ Олон улсын байгууллагын шугамаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэлийн чанарыг баталгаажуулж дараах бичиг баримтыг ирүүлсэн байна.
1. Эмийн бүтээгдхүүний сертификат
 2. Цувралын сертификат
 3. Олон улсын стандартын байгууллагын шаардлага
 4. Хэрэглэх заавар
 5. Эм, эмнэлгийн хэрэгсэлийн үнэ
- /73./ Үйлдвэрлэлийг боловсронгуй болгох асуудлуудыг сонгоно уу.
1. Эмийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний өөрийг өртгийг хямдруулах
 2. Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх
 3. Эмийн зах зээлд өрсөлдөх чадвартай, чанартай эм үйлдвэрлэх нөхцлийг бүрдүүлэх
 4. Эмийн үйлдвэрлэлд оролцож байгаа бүх зүйл нь баримтаар баталгаажигдсан байх
 5. Эмийн үйлдвэрлэлд ашиглагдах техник, тоног төхөөрөмжийг байнга шинэчилж байх
- /74./ Бүртгэгдсэн өөрийн нэрээр хэрэглээнд гарч буй эм нь ямар эм болох вэ ?
1. Женерик эм
 2. Оюуны өмчийн эрхийн хамгаалалтай эм
 3. А ангилалд багтах эм
 4. Оригинал эм
 5. В ангилалд багтах эм
- /75./ Эмийн агуулахын зохион байгуулалтанд ямар шаардлагууд тавигдах вэ?
1. Агуулахын хэмжээ багтаамж
 2. Хүн хүч
 3. Техник технологийн хүчин чадал
 4. Захиалалт, нийлүүлэлт
 5. Татан авалт , хяналт

/76./ Эмийн мэргэжилтнүүд нь ёс зүйн зарчмыг хүлээн зөвшөөрч ажиллах ёстой. Эмийн санчдын ёс зүй нь тэднээс эелдэг даруу, хүнлэг нинжин сэтгэлтэй, үнэнч шударга байхыг шаардана.

/77./ Эмийн мэргэжилтнүүд нь юуны өмнө өвчтөнийг хүндэтгэн үзэж тэдний аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах үүрэгтэй. Яагаад гэвэл эмийн мэргэжилтнүүд нь тангараг өргөнө.

/78./ Сэрүүн газар хадгалах шаардлагатай эмийн жагсаалтанд вазелин орно. Яагаад гэвэл вазелин нь дэгдэмхий шинж чанартай.

/79./ Олон улсын байгууллагын шугамаар нийлүүлэгдэж байгаа эмийн хувиарлалтыг МЭИК хийдэг. Энэ хуваарийн дагуу аймаг хотын эм хангамж компаниудад тээвэрлэн хүргүүлнэ.

/80./ Эмнэлгийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх үйл ажиллагааг эмийн эмчилгээг зохицуулах хороо зохион байгуулана. Энэ хороо нь эмнэлэгт байрлана.

/81./ Хортой эмийн бодисын тритурац бэлтгэхэд туслах бодисоор ямар бодис авдаг вэ?

- A. Глюкоз
- B. Лактоз
- C. Сахароз
- D. Рамноз
- E. Фруктоз

/82./ Нунтаг эмийн хэлбэрийг бэлтгэхэд эмийн бодисын алдагдлыг хэрхэн тооцох вэ?

A. Тухайн бодисын №1 ууранд алдагдах хэмжээг уурын ажлын гадаргуугийн коэффициентоор үржүүлнэ.

B. Тухайн бодисын ууранд алдагдах хэмжээг ажлын гадаргуугийн коэффициентоор үржүүлнэ.

C. Тухайн бодисын жинг уг уурын ажлын гадаргуугийн коэффициентоор үржүүлнэ.

D. Хүснэгтэнд заасан алдааг тухайн бодисын хэмжээнд хувааж олно.

E. Ууранд алдагдах хэмжээг хүснэгтээс харна.

/83./ Цийдмэгийн дисперсийн фазын жижиг хэсгийн хэмжээ хэд вэ?

- A. 1 нм
- B. 1-100 нм
- C. 0,1 -5 мкм
- D. 1-150 мкм
- E. 150-300 мкм

/84./ 10% -ийн натрийн тетраборатын 10 мл нүдний дусал нь нулимсны шингэний хувьд ямар уусмал байх вэ?

- A. Гипотоник
- B. Изотоник
- C. Гипертоник
- D. Изионик
- E. Гипоиник

/85./ Ментолын тосон түрхлэгийн найрлаганы дисперсийн системийн төрөл нь юу вэ?

- A. Нэгэн төрлийн
- B. Хөвмөл хэлбэрийн
- C. Цийдмэг хэлбэрийн
- D. Хосолсон хэлбэрийн
- E. Нийлмэл хэлбэрийн

/86./ Хайлш хэлбэрийн тосон түрхэц бэлтгэхдээ ямар бодисоос эхлэж хайлуулдаг вэ?

- A. Эмийн бодис
- B. Суурь бодисыг
- C. Өндөр температурт хайлдаг суурь бодисыг
- D. Амархан уусдаг бодис
- E. Уусдаггүй бодисыг

/87./ Тосон түрхэцийн найрлаганд дэгдэмхий бодис болох ментол, кампор, тимол, фенол зэрэг бодис орсон байвал сууриндаа яаж оруулах вэ?

- A. Сууриа халааж хайлуулаад нэмнэ
- B. Сууриндаа шууд нэмж хийгээд сайтар хутгана
- C. Хайлуулж хагас хөргөсөн сууриндаа уусгана
- D. Эмийн бодисоо усанд уусгаж уусмал байдалд оруулаад нэмнэ.
- E. Эмийн бодисоо спиртэнд уусгана

/88./ Холимог шингэн эм бэлтгэхэд усыг ямар зорилгоор эхлээд хийдэг вэ?

- A. Сулруулсан уусмал гарган авах зорилгоор

- В. Нэгэн төрлийн уусмал болгох зорилгоор
 С. Ингредиентүүдийн харилцан үйлчлэлцлээс сэргийлэх
 D. Уусгагчийн алдагдлыг багасгах
 E. Бодисуудыг сайн уусгах зорилгоор
- /89./ Бодисыг нунтаглаж хэмжээг нь багасгахад ямар давуу талууд бий болдог вэ?
 A. Шимэгдэх хурд сайжрах, сорьцын бүх төрлүүд ихсэх, шархнаас ялгарч байгаа шингэнийг шингээх чадвар сайжирна
 B. Сорбцын төрлүүд ихсэнэ, хатуу фазуудын харилцан үйлчлэлцэл нэмэгдэнэ.
 C. Хатуу фазуудын харилцан үйлчлэлцэл нэмэгдэнэ.
 D. Шархнаас ялгарч байгаа шингэнийг шингээх чадвар сайжирна.
 E. Шимэгдэх хурд сайжирна, шингэнийг шингээх чадвар сайжирна.
- /90./ Орлуулах коэффициент гэдэг нь
 A. 30 гр зуурдасанд 1 гр ланолин байхаар тооцож авна
 B. 45 гр 1 гр ланолин байхаар тооцож авна
 C. 30 гр зуурдасанд 3 гр ланолин байхаар тооцож авна
 D. 20 гр зуурдасанд 1 гр ланолин байхаар тооцож авна
 E. 30 гр зуурдасанд 2 гр ланолин байхаар тооцож авна
- /91./ Кофеин бензоат натрийн 10% -1000 мл аагтай уусмал бэлтгэхэд шаардагдах усны хэмжээг ол.
 (нягт 1.0341 мл\гр)
 A. 490 мл
 B. 750 мл
 C. 680 мл
 D. 850 мл
 E. 934 мл
- /92./ Желатинан глицеринэн суурийн бүрэлдэхүүн желатин, ус, глицерин ямар харьцаатай байдаг вэ?
 A. 1:2:5
 B. 1:3:5
 C. 1:3:4
 D. 2:2:5
 E. 1:2:6
- /93./ Уур нүдүүрийн хэмжээг яаж сонгох вэ?
 A. Тугналтаас
 B. Нунтагийн масс нь уур нүдүүрийн багтаамжийн 1/20 хэтрэхгүй байх ёстой
 C. Томъёо ашиглаж тооцно.
 D. Баримжаагаар сонгож авна.
 E. Энгийн нүдээр харж сонгоно.
- /94./ Лааг өнхөрүүлэх аргаар бэлтгэхдээ лааны зуурдсыг нягт уян хатан болгохын тулд ланолиныг нэмэхдээ яаж тооцож авах вэ?
 A. 30 гр зуурдасанд 1гр ланолин байхаар тооцож авна
 B. 45 гр гр зуурдасанд 1гр ланолин байхаар тооцож авна
 C. 30 гр гр зуурдасанд 3гр ланолин байхаар тооцож авна
 D. 20 гр гр зуурдасанд 1гр ланолин байхаар тооцож авна
 E. 30 гр гр зуурдасанд 2гр ланолин байхаар тооцож авна
- /95./ Бэлтгэсэн уусмалын концентраци багадсан бол нэмэх хуурай бодисын хэмжээг дараах томъёогоор олно.
 A. $X = a - (b \cdot c) / 100(d - b)$
 B. $X = a(c - b) / b$
 C. $X = a(b - c) / 100d - b$
 D. $X = a(c - b) / b - c$
 E. $X = a(c - b) / 100d - b$
- /96./ Ууранд хамгийн түрүүнд ямар бодисыг нунтагладаг вэ?
 A. Индифферент бодис
 B. Хортой бодис
 C. Тритураци
 D. Будагтай бодис
 E. Хөнгөн бургимтгай бодис
- /97./ Дараах холимог шингэн эмийн нийт эзэлхүүнийг тооцож олно уу?
 Натрийн бромид 5,0
 Адонизид 10 мл
 Бамбайн хандмал 5 мл
 Нэрмэл ус 200 мл хүртэл
 A. 200 мл

- B. 205 мл
- C. 215 мл
- D. 220 мл
- E. 185 мл

/98./ Хөвөн ба самбайн оронд хэрэглэдэг шилэн шүүлтүүрийн хэмжээг заана уу?

- A. Нүхний голч нь 90-120 мкм
- B. Нүхний голч нь 150-200 мкм
- C. Нүхний голч нь 40-150 мкм
- D. Нүхний голч нь 5-15 мкм
- E. Нүхний голч нь 15-40 мкм

/99./ Кофеин бензоат натрийн 10% -1000 мл аагтай уусмал бэлтгэхэд шаардагдах усны хэмжээг ол (нягт 1.0341 мл\г)

- A. 490 мл
- B. 750 мл
- C. 680 мл
- D. 850 мл
- E. 934 мл

/100./ Тритурацийг ямар нөхцөлд бэлтгэдэг вэ?

- A. Жорын найрлаганд хортой эмийн бодис орсон тохиолдолд тритурацийг бэлтгэнэ.
- B. Жорын найрлага дахь хортой эмийн бодисын хэмжээ 0,05 г-аас бага, өөрөөр хэлбэл жигнэх боломжгүй үед тритураци бэлтгэнэ.
- C. Жорын найрлага дахь хортой эмийн бодисын хэмжээ 0,5 г-аас бага, өөрөөр хэлбэл жигнэх боломжгүй үед тритураци бэлтгэнэ.
- D. Жорын найрлага дахь хортой эмийн бодисын хэмжээ 5 г-аас бага, өөрөөр хэлбэл жигнэх боломжгүй үед тритураци бэлтгэнэ.
- E. Жорын найрлаганд хортой эмийн бодис орсон 0.001г-аас бага, өөрөөр хэлбэл жигнэх боломжгүй үед тритурацийг бэлтгэнэ.

/101./ Лаа эмийн хэлбэрт тавигдах шалгууруудад аль нь хамаарагдах вэ?

- 1. Ердийн температурт хатуу байдалтай
- 2. Хүний биеийн температурт хайлдаг
- 3. Эмийн бодисыг хурдан чөлөөлдөг байх ёстой
- 4. Хурдан хайлж салст бүрхэвчээр жигд тархдаг
- 5. Салст бүрхэвчийг цочроох нөлөө үзүүлдэггүй

/102./ Ариутгалын физикийн аргуудад юу орох вэ?

- 1. Дулааны ариутгал
- 2. Хэт ягаан туяаны ариутгал
- 3. Радиацийн ариутгал
- 4. Шүүлтийн ариутгал
- 5. Химийн ариутгал

/103./ Жин-Эзэлхүүний аргаар ямар уусмалуудыг бэлтгэдэг вэ?

- 1. Усан уусмал
- 2. Спиртэн уусмал
- 3. Коллоид уусмал
- 4. Тосон уусмал
- 5. Жоронд уламжлалт нэрээр бичигдсэн стандарт шингэн

/104./ Нүдний дусал үйлдвэрлэх технологийн үе шатанд аль нь хамаарагдах вэ?

- 1. Тюбик дусаагуурын их бие таглааг үйлдвэрлэх
- 2. Эмийн бодисыг уусгах
- 3. Шалгах, савлах
- 4. Нэр бичих
- 5. Уусмалыг их биенд дүүргэх

/105./ Үрэл эм үйлдвэрлэхэд ордог туслах бодисуудыг сонго.

- 1. Сахар
- 2. Цардуул
- 3. Тальк
- 4. Шоколад
- 5. Хүнсний будаг

/106./ Лааны сууринд тосон түрхэцийн сууриас ялгагдах ямар өвөрмөц шаардлагууд тавигддаг вэ?

- 1. Биеийн температурт уусдаг
- 2. Биеийн темдературт хайлдаг
- 3. Тасалгааны температурт хатуу
- 4. Эмийн бодисыг хурдан чөлөөлдөг

5. Зөөлөн консистенцтэй байх
- /107./ 10%-ийн декстраныг натрийн хлоридийн изотоник уусмалд бэлтгэсэн бэлдмэлийг нэрлэнэ үү?
1. Гемодез
 2. Гемаксель
 3. Полиглюкин
 4. Реополиглюкин
 5. Полидес
- /108./ Жоронд шулуун гэдэсний лааны жинг заагаагүй бол 1 лааны хэмжээг ямар жинтэй байхаар тооцох вэ?
1. 2.0
 2. 4.0
 3. 4,5
 4. 3,0
 5. 3.5
- /109./ Ходоод гэдэсний замаар хэрэглэдэг эмийн хэлбэрт аль хамаарагдахыг заана уу?
1. Амаар хэрэглэх
 2. Шулуун гэдсээр хэрэглэх
 3. Хэлэн дор тавих
 4. Ингаляцаар хэрэглэх
 5. Хамар чихэнд дусаах
- /110./ Ходоод гэдэсний замаар хэрэглэдэг эмийн хэлбэрт аль нь хамаарагдахыг заана уу?
1. Амаар хэрэглэх
 2. Шулуун гэдсээр хэрэглэх
 3. Хэлэн дор тавих
 4. Ингаляцаар хэрэглэх
 5. Хамар чихэнд дусаах
- /111./ Идээшмэл бэлтгэхдээ
1. Усан халаагуур дээр 15 минут халаана
 2. 3,3 л хүртэл хэмжээтэй бол усан халаагуур дээр 25 минут халаана
 3. Тасалгааны температурт 45 минут хөргөнө
 4. Усан халаагуур дээр 30 минут халаана
 5. Тасалгааны температурт
- /112./ Эмийн үйлдвэрлэлийн процессыг явуулахад шаардлагатай гол хүчин зүйлүүдийг нэрлэ.
1. Машин тоног төхөөрөмж
 2. Түүхий эд, материал
 3. Эрчим хүч
 4. Ажиллах хүчин
 5. Ажлын байр
- /113./ Дараах уусгагчдаас аль нь дэгдэмхий биш уусгагч вэ?
1. Этанол
 2. Хлороформ
 3. Эфир
 4. Глицерин
 5. Өөх тос
- /114./ Стандарт фармакопейн II бүлгийн шингэнүүд
1. Аммиакийн 9,5-10,5% уусмал багтана
 2. Цууны хүчлийн 98%, 30% уусмалууд багтана
 3. Сулруулалтын томьёо ашиглана
 4. Сулруулахдаа стандарт фармакопейн шингэнийг 100% цэвэр бодис гэж тооцно
 5. Давсны хүчлийн уусмалууд багтана
- /115./ Үхрийн өөхийг органик уусгагчудад уусгаад талстжуулж, хатуу глицеридээс тусгаарлаж гаргаж авах ба 35-370-т хайлдаг лааны суурийг нэрлэнэ үү?
1. Бутирол
 2. Ланоль
 3. Витепсол
 4. Себувинол
 5. Массупол
- /116./ Идээшмэл бэлтгэхдээ
1. Усан халаагуур дээр 15 минут халаана
 2. 3,3 л хүртэл хэмжээтэй бол усан халаагуур дээр 25 минут халаана
 3. Тасалгааны температурт 45 минут хөргөнө
 4. Усан халаагуур дээр 30 минут халаана

5. Тасалгааны температурт 10 минут хөргөнө
- /117./ Лааг ямар шалгуураар стандартчилдаг вэ?
1. Мэдрэхүйн эрхтэнээр
 2. Хайлах температур
 3. Механик бат бэх чанар
 4. Деформацид орох хугацаа
 5. Дундаж жин, зэвшөөрөгдөх хэлбэлзэл
- /118./ Тосон түрхэц бэлтгэх технологийн үе шатанд аль нь хамаарагдах вэ?
1. Хайлуулах, уусгах
 2. Дисперсжүүлэх
 3. Эмийн бодисыг хэмжин авах
 4. Хатаах
 5. Буцалгах
- /119./ Хөвмөл хэлбэрийн тосон түрхэц дэх эмийн бодисын жижиглэлтийн хэмжээг микроскопын тусламжтайгаар тодорхойлоход дараах шаардлагыг хангасан байх ёстой.
1. Германы фармакопейд тосон түрхэцэн дэх эмийн бодисын жижиг хэсгийн хэмжээ 60 мкм-ээс томгүй, нүдний тосон түрхэцэнд 50 мкм-ээс томгүй байх ёстой
 2. АНУ-ын ФК-д нүдний тосон түрхэцэн дэх эмийн бодисын хэмжээ 50 мкм-ээс томгүй байх ёстой
 3. ОХУ-ын ФК-д тосон түрхэцэнд 50 мкм-ээс томгүй хэсгүүд 5%-иас хэтрэхгүй байна
 4. Босины аргаар тодорхойлоход 60мкм-ээс томгүй хэсгүүд 5% -иас хэтрэхгүй байна
 5. Чулковын аргаар тодорхойлоход 60 мкм-ээс томгүй хэсгүүд 3%-иас хэтрэхгүй байна
- /120./ Ханасан уурын даралтын дор автоклаваар шил, металл, шаазан эдлэлийн ариутгах дэглэмийг заана уу?
1. 1190-1210-т 20-30 минут
 2. 1190-1210-т 8-15 минут
 3. 1190-1210-т 10-15 минут
 4. 1190-1210-т 20-40 минут
 5. 1190-1210-т 15-20 минут
- /121./ Коллоид уусмалын шинж чанарыг нэрлэнэ үү?
1. Гадна байдал нь тунгалаг \солонгорсон\
 2. Жижиг хэсгүүд нь цаасан шүүлтүүрээр нэвтэрнэ
 3. Жижиг хэсгүүд нь ультра шүүлтүүрээр нэвтрэхгүй
 4. Жижиг хэсгүүд нь мембранаар нэвтрэхгүй
 5. Харьцангуй тогтворгүй
- /122./ Ямар тохиолдолд үрлийг туслах шингэн ашиглахгүй бэлдэж болох вэ?
1. Эмийн бодис нь өндөр липофиль шинж чанартай бол
 2. Эмийн бодис нь бага зэрэг липофиль чанартай
 3. Эмийн бодис нь гидрофоб шинж чанартай бол
 4. Эмийн бодис нь өндөр гидрофиль шинж чанартай бол
 5. Эмийн бодис нь бага зэрэг гидрофиль шинж чанартай бол
- /123./ Хосолсон тосон түрхлэг гэж юу вэ?
1. Эмийн бодисыг туслах шингэн ашиглан уусгах замаар гарган авсан тосон түрхлэг
 2. Эмийн бодисуудыг усанд уусгах замаар гарган авсан тосон түрхлэг
 3. Зарим эмийн бодисыг усанд уусгаж, заримыг нь сууринд уусгаж гаргаж авсан нийлмэл тосон түрхлэг
 4. Уусмал, хөвмөл, эмульсийн бүхий л шинж чанарыг хадгалсан нийлмэл тосон түрхлэг
 5. Эмийн бодисуудыг ус болон тос, эмульгаторт уусгаж гарган авсан тосон түрхлэг
- /124./ Тосон түрхэцээс эмийн бодис шимэгдэх процессыг сайжруулах сууринд ямар суурь хамаарагддаг вэ?
1. Вазелин
 2. Ланолин ургамалын тостой холимог
 3. Силиконон суурь
 4. Константны эмульсэн суурь ус/вазелин
 5. Загасан тос
- /125./ Лаа бэлтгэхдээ тосонд уусдаг эмийн бодисыг найрлаганд нь яаж оруулдаг вэ?
1. Усанд уусгаж оруулна.
 2. Хөвмөл байдлаар оруулна.
 3. Эмульс байдлаар оруулна.
 4. Тосон сууринд уусгана.
 5. Хосолсон байдлаар оруулна

/126./ Нийлмэл нунтаг бэлтгэх технологийг уур нүдүүрийг сонгож авахаас эхэлнэ. Яагаад гэвэл нунтагийн бүх жин нь уурын тохиромжтой ачаалалд ойрхон байх бөгөөд дээд ачааллаас хэтрэхгүй байх ёстой.

/127./ Шилэн шүүлтүүрээр шүүхэд уусмалын эзэлхүүн нь хорогддоггүй сайн талтай. Ийм учраас алкалоид, будагч бодис, ферментийн уусмалыг шүүхэд хэрэглэж болохгүй.

/128./ Тарилгын уусмалыг бэлтгэхэд хэрэглэгддэг эмийн бодисууд нь чанарын хувьд фармакопейн шаардлага хангасан химийн цэвэр ба шинжилгээнд зориулсан цэвэр зэрэглэлийн бодисууд байх ёстой. Яагаад гэвэл эмийн бодис нь заавал ямар нэгэн хольцыг өөртөө агуулсан байдаг.

/129./ Гадуур ба дотуур хэрэглэх шингэн эмийн хэлбэрийг жин, жин-эзлэхүүний аргаар бэлтгэж эзлэхүүнээр олгоно. Яагаад гэвэл 5% ба түүнээс дээш эмийн бодис орсон цийдмэгийг аагтай цийдмэг гэнэ.

/130./ Усан ялгамал нь бичил биетэн үржих тохиромжтой орчин учир амархан мууддаг. Яагаад гэвэл усан ялгамалыг бэлтгэж буй технологи нь түүнийг ариун чанартай болгож чаддаггүй.

/131./ Дисперсийн системийн ангилалаар ямар дисперсийн системийн фаз нь ион молекул байдаг вэ?

- A. Бага молекулт нэгдэл
- B. Өндөр молекулт нэгдэл
- C. Коллоид уусмал
- D. Хөвмөл
- E. Цийдмэг

/132./ Ланолиний тосон түрхлэгийн найрлаганы дисперсийн системийн төрөл нь юу вэ?

- A. Нэгэн төрлийн
- B. Хөвмөл хэлбэрийн
- C. Цийдмэг хэлбэрийн
- D. Хосолсон хэлбэрийн
- E. Нийлмэл хэлбэрийн

/133./ Колларгол, пепсин бэлтгэх технологийг сонго.

- A. Усны гадаргуу дээр цацаад хөдөлгөхгүй байлгах, халаах
- B. Тасалгааны хэмд хөөлгөх, халаагаад сайн жижиглэх
- C. Устай жижиглэх, хүчиллэгжүүлсэн усанд уусгах
- D. Халааж уусгах, хөвмөл байдлаар буцалж буй ус руу хийх
- E. Устай жижиглэх, халаах сайн жижиглэх

/134./ Лааг ямар шалгуураар стандартчилдаг вэ?

- A. Эмийн бодисын хэмжээгээр
- B. Хайлах температур
- C. Механик бат бөх чанар
- D. Бүрэн уусах хугацаа
- E. Бүрэн задрах хугацаа

/135./ Дараах уусмалыг бэлтгэх тооцоо хий

Rp: Sol. Ammonii caustici 3%-200 ml

D.S хүйд дусаана

- A. 20 мл стандарт фармакопейн шингэн 180 мл нэрмэл ус
- B. 6,7 мл стандарт фармакопейн шингэн 193,3 мл нэрмэл ус
- C. 24 мл стандарт шингэн 176 мл нэрмэл ус
- D. 6 мл стандарт шингэн 194 мл нэрмэл ус
- E. 20,8 мл стандарт шингэн 179,2 мл нэрмэл ус

/136./ Ямар ч түүхий эдийг хандлахын өмнө заавал дэвтээх шаардлагатай. Учир нь дэвтээхэд түүхий эд хөөж, хадлагч шингэн орох боломж сайжирна.

/137./ Мацерацын аргыг хуйлруулж хандлах замаар эрчимжүүлж болно. Учир нь квитацын үзэгдэл хандлалтыг түргэснэ.

/138./ Хандлалтын үед концентрацын ялгааг ихэсгэхийн тулд хандалгчийг үе үе солино. Учир нь концентрацын ялгаа их байх нь хандлах процессыг нэмэгдүүлэнэ.

/139./ Хандыг тунгаахад хамгийн тохиромжтой температурыг заана уу?

- A. +8+100
- B. +10+120
- C. -8-100
- D. -10-120
- E. +6+80

/140./ Шинэ галены технологт хэрэглэдэг давсжуулах аргад натрийн хлоридыг өргөн хэрэглэдэг учрыг тайлбарлана уу.

- A. Хамгийн хүчтэй электролит шинж чанартай
- B. Хамгийн хямд, өргөн олдоцтой
- C. Ургамлын бэлдмэлээс дараа нь ялган авахад хялбар
- D. Хүчтэй химийн нөлөө үзүүлдэггүй
- E. Осмос даралт буй болгодог

/141./ Хуурай экстракт-концентрацыг ямар харьцаагаар бэлтгэх вэ?

- A. 15
- B. 1:1
- C. 1:2
- D. 1:10
- E. 1:20

/142./ 1 секундэнд 1м² гадаргуугаар, 1м зузаантай үеэр, 1кг\м³ концентрацитай ялгаагаар диффузлэгдсэн бодисын концентрацийн хэмжээг юу гэж нэрлэдэг вэ?

- A. Конвектив диффузи
- B. Молекул диффузи
- C. Фикийн диффузийн хууль
- D. Масс шилжилтийн диффузи
- E. Гидродинамик нөхцөл

/143./ Зөвхөн шинэ галены бэлдмэлийн үйлдвэрлэлд ашиглагдах үе шатыг заана уу?

- A. Түүхий эд экстрагентыг бэлтгэх
- B. Хандлах
- C. Цэвэрлэх
- D. Техникийн бэлэн бүтээгдэхүүн гарган авах
- E. Стандартчилах

/144./ Үр жимсийн жижиглэлтийн хэмжээг заана уу?

- A. 0,3-0,5 мм
- B. 0,5-2,0 мм
- C. 1-3 мм
- D. 3-5 мм
- E. 0,5-1 мм

/145./ Түүхий эдийг тэнцүү хэмжээгээр 3 перколяторт хуваан хийж 1-р перколятороос эхлэн хандлах аргыг нэрлэнэ үү?

- A. Хэсэгчилсэн мацерацын арга
- B. Перколяцын арга
- C. Мацерацын арга
- D. Босины арга
- E. Германы фармакопейн арга

/146./ Галены бэлдмэлүүд нь ямар бодис агуулсан бэлдмэлүүд вэ?

- A. Химийн цэвэр бодис агуулсан бэлдмэл
- B. Биологийн идэвхт бодисуудыг нийлмэл байдлаар агуулсан бэлдмэл
- C. Ургамал, амьтны гаралтай түүхий эдэд агуулагдах биологийн идэвхт бодисуудыг дагалдах бодисуудын хамтаар нийлмэл байдлаар агуулсан бэлдмэл
- D. Ургамал амьтны гаралтай түүхий эдэд агуулагдах бодисуудыг комплексоор нь агуулсан бэлдмэл
- E. Биологийн идэвхт бодис дангаар нь агуулсан бэлдмэл

/147./ Ялгамал гаргаж авах хэсэгчилсэн мацерацын аргын онцлог юу вэ?

- A. Түүхий эд, экстрагентыг 4 хувааж хандлана.
- B. Түүхий эдийг 2 хувааж экстрагентыг хуваахгүйгээр хийж хандлалтыг явуулна.
- C. Экстрагентыг 2 хувааж, эхний удаад түүхий эдээс 4-6 дахин их хэмжээний экстаргентаар 6-12 цаг хандлана, үлдэгдлийг 3-4 дахин их хэмжээний экстаргентаар 4- 6 цаг хандлаад, ялгамлуудыг нийлүүлнэ.
- D. Түүхий эд, экстрагентыг 8 хувааж хандлана.
- E. Экстрагентыг хуваахгүйгээр 6-12 цаг хандлана.

/148./ Халаалт хэрэглэхгүйгээр ямар бэлдмэлийг гаргах вэ?

- A. Өтгөн ханд

- B. Хуурай ханд
- C. Тосон ханд
- D. Шингэн ханд
- E. Хандмал

/149./ Хортой ба хүчтэй үйлчлэгч бодис агуулаагүй ургамлын түүхий эдээс хандыг ямар харьцаатайгаар бэлтгэдэг вэ?

- A. 1:10
- B. 1:5
- C. 1:2
- D. 1:100
- E. 1:150

/150./ Перколяцийн аргаар хандлалт явуулахдаа түүхий эдийг норгоход хэдийн хэмжээний хандлагч хэрэглэх вэ?

- A. Түүхий эдээс 1 дахин их
- B. Түүхий эдээс 2 дахин их
- C. Түүхий эдийн хагастай тэнцэх
- D. Түүхий эдийн 1/3-тай тэнцэх
- E. Түүхий эдийн j-тай тэнцэх

/151./ Тиреодиний бэлдмэлийг ямар түүхий эдээс гаргах вэ?

- A. Бөөрний дээд булчирхай
- B. Өнчин тархи
- C. Төмсөг
- D. Нойр булчирхай
- E. Бамбай булчирхай

/152./ Нимбэгний хальснаас эфирийн тос гарган авахад ашиглагдах аргыг заана уу?

- A. Шахах арга
- B. Усны ууртай нэрэх арга
- C. Хандлах арга
- D. Анфлеражийн арга
- E. Динамик адсорбцын арга

/153./ Хоорондоо холилдоогүй хоёр шингэний хооронд бодис шилжих үзэгдлийг ашиглан шинэ галены бэлдмэлийг цэвэрлэх аргыг сонго.

- A. Диализын арга
- B. Сорбцийн арга
- C. Шингэнээр экстракцлах арга
- D. Хандлах арга
- E. Конвектив диффузи

/154./ Өтгөн хандны онцлог шинж чанар юу вэ?

- A. Түүхий эдээс хандлагдах бодисын хэмжээ нь 5% хүрдэг учраас тогтвор муутай байдаг.
- B. Хадгалах явцад температурын хэлбэлзлэлээс болж ялангуяа температур багасахад, экстрагент нь ууршиж тунадас унаж болдог.
- C. Хуурай агаарт хатаж, хатуу бөөгнөрсөн массыг үүсгэх ба чийгтэй агаарт хөгцөрдөг.*
- D. Түүхий эдээс хандлагдах бодисын хэмжээ нь 100% хүрдэг учраас тогтвор муутай байдаг.
- E. Экстрагент нь ууршиж тунадас унадаг.

/155./ Дараах шинж чанараас аль нь технологийн шинж чанарт хамаарах вэ?

- A. Жижиг хэсгийн хэмжээ
- B. Чийглэг
- C. Хандлагдах бодисын хэмжээ
- D. Шингэнийг түрж гаргах коэффициент
- E. Үнслэг

/156./ Ямар биологийн идэвхт бодисыг ургамалаас гарган авахийн тулд урьдчилан хүчлийн уусмал нэмэх вэ?

- A. Флавноид
- B. Алкалоид
- C. Кумарин
- D. Нүүрс ус
- E. Эфирийн тос

/157./ Хандмалыг хэрхэн ангилах вэ?

1. Өтгөн
2. Энгийн
3. Тосон
4. Нийлмэл

5. Экстракт концентрац
- /158./ Хатааж тосгүйжүүлэн жижиглэсэн эд, эрхтэний бэлдмэлийн технологийн процессийг нэрлэнэ үү?
1. Түүхий эдийг хатаах
 2. Тосгүйжүүлэх
 3. Жижиглэх
 4. Эмийн хэлбэрт оруулах
 5. Хандлах
- /159./ Цэцгийн тос гарган авах аргыг заана уу?
1. Шахах арга
 2. Усны ууртай нэрэх арга
 3. Хандлах арга
 4. Анфлеражийн арга
 5. Динамик адсорбцын арга
- /160./ Хатаасан ургамлын түүхий эд нь шинэ түүсэн ургамлын түүхий эдийг бодвол биондэвхт бодисын найрлага ба агууламж нь өөр байдаг. Үүний шалтгаан нь юу вэ?
1. Уурших, дэгдэх, агаарын хүчилтөрөгч, гаднын бусад нөлөөгөөр чанар, тооны өөрчлөлтөнд орсон байдаг.
 2. Эсийн ханын хагас нэвтрүүлэх шинж алдагдсан байдаг тул хандлагдахдаа сайн болдог.
 3. Ферментийн нөлөөгөөр задралд орсон байдаг.
 4. Үйлчлэгч бодис нь гидролизд орсон байдаг.
 5. Дагалдах бодисууд хандлах процесст муугаар нөлөөлдөг.
- /161./ Хуурай хандны чанарыг ямар шалгуураар шалгадаг вэ?
1. Чийглэг
 2. Хүнд металлын хэмжээ
 3. Үйлчлэгч бодисын хэмжээ
 4. Ялгамалын нягт
 5. Ялгамалын савлагаа
- /162./ Реперколяцийн аргад түүхий эдийг тэнцүү хэмжээгээр хувааж хийдэг ямар аргууд байдаг вэ?
1. АНУ-ын ФК-н арга
 2. Босины арга
 3. Германы ФК-н арга
 4. Чулковын арга
 5. Циркуляцийн арга
- /163./ Ферментийн гаралтай бэлдмэлийг ямар аргаар ариутгах нь хамгийн зохимжтой вэ?
1. Дулааны
 2. Химийн
 3. Өндөр даралтан дор ариутгах
 4. Мембранан шүүлтүүрээр шүүх
 5. Механик арга
- /164./ Түүхий эдээс болон эмийн бодис нэмж идээшмэл, чанамал бэтгэх технологт аль нь хамаарагдах вэ?
1. Түүхий эдийг жижиглэх
 2. Хандлах
 3. Эмийн бодисоо оруулах
 4. Өтгөрүүлэх
 5. Ялгах
- /165./ Май цэцгийн хандмалд агуулагдах бодисыг заана уу?
1. Сапонин
 2. Эфирийн тос
 3. Флавноид
 4. Зүрхний гликозид
 5. Алкалоид
- /166./ Шинэ галены бэлдмэл гарган авахад өөр өөр хандлагчдыг дараалан хэрэглэх нь ямар зорилго агуулдаг вэ?
1. Химийн хувьд нэгэн төрлийн цэвэр бодис ялган авах
 2. Дагалдах бодисыг аль болох уусгахгүй байх
 3. Өөр өөр хандлагчид уусдаг бодисуудыг дараалуулан ялгах
 4. Тогтвортой, тунадас үүсгэдэггүй бэлдмэл ялган авах
 5. Муутгахаас хамгаалан цэвэрлэгээ хийдэг.
- /167./ Хандмалыг хадгалах нөхцөлүүдийг нэрлэнэ үү?
1. Гэрлээс хамгаалах

2. Ууршилтаас хамгаалах
3. Температурын нөлөөнөөс хамгаалах
4. Чийгнээс хамгаалах
5. Задралтаас хамгаалах

1-C, 2-C, 3-D, 4-B, 5-C, 6-B, 7-B, 8-A, 9-C, 10-A, 11-B, 12-A, 13-E, 14-C, 15-B, 16-D, 17-C, 18-C, 19-B, 20-C, 21-A, 22-C, 23-A, 24-A, 25-A, 26-A, 27-E, 28-A, 29-C, 30-A, 31-D, 32-D, 33-E, 34-B, 35-E, 36-E, 37-C, 38-D, 39-D, 40-C, 41-A, 42-A, 43-C, 44-D, 45-D, 46-D, 47-A, 48-C, 49-D, 50-D, 51-B, 52-A, 53-C, 54-A, 55-E, 56-C, 57-B, 58-A, 59-B, 60-D, 61-E, 62-E, 63-B, 64-A, 65-C, 66-E, 67-A, 68-E, 69-B, 70-E, 71-C, 72-B, 73-E, 74-D, 75-E, 76-A, 77-C, 78-C, 79-D, 80-A, 81-B, 82-A, 83-D, 84-C, 85-D, 86-C, 87-C, 88-C, 89-A, 90-A, 91-E, 92-A, 93-B, 94-A, 95-C, 96-A, 97-E, 98-C, 99-E, 100-B, 101-E, 102-E, 103-A, 104-E, 105-E, 106-B, 107-D, 108-D, 109-A, 110-A, 111-E, 112-E, 113-E, 114-A, 115-D, 116-A, 117-E, 118-A, 119-A, 120-D, 121-E, 122-D, 123-D, 124-C, 125-D, 126-A, 127-C, 128-C, 129-B, 130-A, 131-A, 132-D, 133-C, 134-E, 135-A, 136-D, 137-B, 138-C, 139-E, 140-B, 141-D, 142-D, 143-D, 144-A, 145-D, 146-C, 147-C, 148-E, 149-B, 150-C, 151-E, 152-A, 153-C, 154-C, 155-D, 156-B, 157-C, 158-B, 159-C, 160-B, 161-A, 162-C, 163-A, 164-A, 165-D, 166-A, 167-A, 168-D, 169-C, 170-A, 171-C, 172-C, 173-A, 174-A, 175-C, 176-B, 177-C, 178-C, 179-C, 180-B, 181-A, 182-C, 183-C, 184-C, 185-B, 186-C, 187-B, 188-D, 189-D, 190-A, 191-C, 192-C, 193-E, 194-D, 195-C, 196-A, 197-C, 198-B, 199-C, 200-A, 201-E, 202-D, 203-C, 204-A, 205-E, 206-D, 207-B, 208-D, 209-B, 210-C, 211-B, 212-C, 213-B, 214-D, 215-B, 216-D, 217-B, 218-C, 219-A, 220-E, 221-A, 222-A, 223-A, 224-D, 225-C, 226-C, 227-D, 228-C, 229-A, 230-C, 231-C, 232-C, 233-E, 234-D, 235-C, 236-A, 237-C, 238-A, 239-B, 240-A, 241-C, 242-A, 243-C, 244-B, 245-B, 246-C, 247-C, 248-B, 249-A, 250-A, 251-D, 252-D, 253-B, 254-D, 255-C, 256-C, 257-B, 258-D, 259-A, 260-D, 261-E, 262-B, 263-D, 264-D, 265-B, 266-D, 267-B, 268-B, 269-A, 270-A, 271-A, 272-D, 273-A, 274-C, 275-A, 276-A, 277-B, 278-E, 279-C, 280-A, 281-D, 282-A, 283-A, 284-D, 285-A, 286-A, 287-E, 288-C, 289-B, 290-E, 291-E, 292-B, 293-D, 294-B, 295-B, 296-E, 297-C, 298-D, 299-A, 300-D, 301-E, 302-B, 303-A, 304-E, 305-A, 306-C, 307-C, 308-C, 309-C, 310-E, 311-C, 312-A, 313-A, 314-E, 315-B, 316-A, 317-E, 318-C, 319-E, 320-B, 321-E, 322-A, 323-B, 324-B, 325-C, 326-C, 327-C, 328-A, 329-D, 330-A, 331-E, 332-B, 333-C, 334-B, 335-B, 336-B, 337-C, 338-C, 339-B, 340-B, 341-E, 342-B, 343-D, 344-E, 345-A, 346-C, 347-A, 348-A, 349-D, 350-A,

Хувилбар 2

- /1./ Эм найруулагчийн ажлын ширээний өндөр хөдөлмөр зохион байгуулалт ёсоор хэд байх ёстой вэ?
А. Хэмжээ харгалзахгүй
В. 75-90 см
С. 65-95 см
D. 60-60 см
E. 75-100 см
- /2./ Ямар эмийг найруулсны дараа олгох хүртлээ битүүмжлэнхадгалж байх ёстой?
А. Хортой эм
В. 0-1 насны хүүхдийн эм
С. Тарилгын эм
D. Нүдний эм
E. Өндөр настны эм
- /3./ Эмийн санд хэд хоногт их цэвэрлэгээг хийж байх ёстой вэ?
А. Сард 1 удаа
В. 7 хоногт
С. 14 хоногт
D. 10 хоногт
E. Өдөр болгон
- /4./ Эмийн санд этилийн спиртийг яаж хадгалах вэ?
А. Төмөр саванд давхар хийнэ.
В. Хүрэн өнгийн шилэнд хийж харанхуй газар
С. 20 С хэмд
D. Шилэн бөглөөтэй саванд хийж сэрүүн газар хадгална
E. Харанхуй газар хадгална.
- /5./ Эм найруулагч ээлжиндээ бэлтгэж амжаагүй жорыг яах ёстой вэ?
А. Маргааш нь найруулна.
В. Жорыг буцаана
С. Эм савлагчаар бэлтгүүлнэ.
D. Дараагийн ээлжийн найруулагчид хүлээлгэн өгнө.

- Е. Хүлээлгийн хуудас бичнэ
- /6./ Мөнгөний нитратыг нягт таглаатай хүрэн шилэнд хийж, гадуур нь хар цаасаар ороожээ. Ямар шинж чанартай учраас ингэж хадгалж байна вэ?
- А. Дэгдэмхий бодис
 - В. Чийгнээс хамгаалж хадгалах бодис
 - С. Температурын нөлөөнөөс хамгаалж хадгалах бодис
 - Д. Гэрлийн нөлөөгөөр урвалд ордог бодис
 - Е. Сэрүүн газар хадгалах бодис
- /7./ Эмийн санд аагтай уусмалыг хичнээн хоногийн нөөцтэйгээр бэлтгэх вэ?
- А. 2-3
 - В. 3-4
 - С. 3-5
 - Д. 7
 - Е. 14
- /8./ Эмийн сангийн жор баригч гэнэт солигдох эсвэл ээлжийн амралтаа авах тохиолдолд ямар тооллого хийгдэх вэ?
- А. Шалгалтын
 - В. Төлөвлөгөөт
 - С. Хяналтын
 - Д. Ээлжийн
 - Е. Гэнэтийн
- /9./ Эмийн санд хугацаат эмийн бүртгэлийг хэн хөтлөх вэ?
- А. Эрхлэгч
 - В. Жор баригч
 - С. Эм найруулагч
 - Д. Дефектар
 - Е. Касс
- /10./ Эмийн жоронд эмийн бэлдмэлийн нэрийг ямар нэрээр бичих вэ?
- А. Олон улсын нэршил
 - В. Үйлчлэгч бодисын нэрээр
 - С. Патентын бус худалдааны нэрээр
 - Д. Химийн нэрээр
 - Е. ФК-н нэршил
- /11./ Эмийн сангийн хана мебель, тоног төхөөрөмжүүд нь ямар өнгөтэй байвал тохиромжтой вэ?
- А. Цайвар шар, цагаан
 - В. Улаан, улаан хүрэн
 - С. Ягаан цагаан
 - Д. Ямар ч өнгө байж болно
 - Е. Цэнхэр шар
- /12./ Эмийн сангаас явуулах эмийн мэдээллийг хэрхэн ангилж болох вэ?
- А. Эмч, хөдөлмөрчид
 - В. Эмч, эм зүйч, хэрэглэгч
 - С. Эмч, эм зүйч
 - Д. Эмч нарт
 - Е. Хөдөрмөрчид, эмч нарт
- /13./ Эрүүл мэндийн тухай хуулийн “эм барих” гэсэн нэр томъёог зөв онооно уу.
- А. Анагаах ухааны дээд , дунд боловсролтой эм зүйч, эм найруулагчдын явуулах үйл ажиллагаа
 - В. Эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг найруулах, савлан бэлтгэх, шалгах, олгох үйл ажиллагаа
 - С. Эмийг жороор болон жоргүй худалдах
 - Д. Анагаах ухааны дээд дунд боловсролтой эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллагаас мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан эмзүйч, эм найруулагчдын явуулах үйл ажиллагаа
 - Е. Эмийн санд эм найруулах
- /14./ Эмийн сангийн цэвэр ашиг гэдэг нь
- А. Эм барааны жижиглэнгийн ба бөөний үнийн зөрүү
 - В. Худалдааны орлого ба гүйлгээний зардлын зөрүү
 - С. Эм бараа борлуулалт ба гүйлгээний зардлын зөрүү
 - Д. Жижиглэнгийн борлуулт ба ашгийн зөрүү
 - Е. Хорогдолтой үнийн зөрүү
- /15./ Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн бодлогын үндсэн зорилт нь
1. Эмчилгээний өндөр идэвхтэй
 2. Гаж сөрөг нөлөө багатай

3. Хэрэглэхэд тохиромжтой
 4. Боломжийн үнэтэй
 5. Чанар сайтай эмээр хангах явдал юм
- /16./ Кальци хлоридын нунтгийг нягт таглагддаг, шилэн саванд хийж таглааг нь лааньтосоор битүүмжилжээ. Ямаршинж чанартай учраас ингэж хадгалж байна вэ?
1. Үнэрт бодис
 2. Дэгдэмхий бодис
 3. Будагч бодис
 4. Талст усаа алддаг
 5. Хортой
- /17./ Тосон түрхэцүүдийг ямар нөхцөлд хадгалах вэ?
1. Хуурай нөхцөлд
 2. Сэрүүн нөхцөлд
 3. Бусад эмийн бодисоос тусад нь
 4. Гэрлээс хамгаалсан нөхцөлд
 5. Үйлдвэрийн сав баглаанд
- /18./ Тооллогыг ямар журмаар явуулах вэ?
1. Үсгийн дарааллаар тоолно.
 2. Зайлшгүй шаардлагатай эмийг нь эхлэн тоолно.
 3. Фармакологийн үйлдлээр нь эхлэж тоолно.
 4. Нэг захаас нь эхлэн нөгөө захыг нь дуустал нь дарааллаар тоолно
 5. Нунтаг эмнээс нь эхлэн хэмжиж тоолно
- /19./ Эмийн зохисгүй хэрэглээнд нөлөөлөх хүчин зүйлүүдийг сонго.
1. Эм хангамжийн систем
 2. Эм олгогч
 3. Жор бичигч
 4. Эмийн сан
 5. Хүн ам
- /20./ Шингэн эмүүдийг яаж хадгалах вэ?
1. Хуурай нөхцөлд
 2. Сэрүүн нөхцөлд
 3. Бусад эмийн бодисоос тусад нь
 4. Гэрлээс хамгаалсан нөхцөлд
 5. Үйлдвэрийн сав баглаанд
- /21./ Үйлчлүүлэгсэд, өвчтөнд өгөх эмийн мэдээллийг сонгоно уу.
1. Өөрийгөө дур мэдэн эмчлэхийн хор холбогдол
 2. Эмийг хэрэглэж байгаа үед гарч болох хариу урвал
 3. Эмийг гэрийн нөхцөлд хэрхэн хадгалах
 4. Эмийн чанарыг шалгах арга
 5. Эмийн үнэ
- /22./ Эмийг сонгох шалгууруудыг нэрлэнэ үү
1. Эмнэлгийн тусламжийн янз бүрийн түвшинд хэрэглэж болохоор байх
 2. Эмнэлгийн ажилтны мэргэжлийн мэдлэг, дадлага, туршлагын хэмжээнд тохирохоор байх
 3. Өвчин эмгэгийг анагаах эмчилгээний идэвх сайтай байх
 4. Элдэв гаж нөлөө , хор аюулгүй байх
 5. Өвчтөн хэрэглэхэд аль болох хялбархан байх
- /23./ Ямар тохиолдолд төлөвлөгөөт бус тооллогыг заавал хийх ёстой вэ ?
1. Эм барааны үнэ өөрчлөгдөхөд
 2. Эд хариуцагч солигдоход
 3. Хулгай, дээрэм болон байгалийн гэнэтийн аюул ослын дараа
 4. Жилийн эцэст
 5. Хүссэн үедээ
- /24./ Үрэл шахмал эмүүдийг ямар нөхцөлд хадгалах вэ?
1. Хуурай нөхцөлд
 2. Гэрлээс хамгаалсан нөхцөлд
 3. Үйлдвэрийн сав баглаанд
 4. Сэрүүн нөхцөлд
 5. Бусад эмийн бодисуудаас тусад нь
- /25./ Мөнгөний баримт бичиг нь засваргүй бичигдэнэ. Учир нь засвартай эмийн сангийн бүх баримтуудыг устгана

/26./ Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийг эмчилгээний зорилгоор ашиглах журам, нөхцлийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална. Хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах болон сэтгэц нөлөөт эмээр үйлчлэх, худалдах журмыг тогтоохдоо Эм, эмнэлгийн хэрэгсэлийн тухай хуулийн 16.1.1-д заасныг баримтлана.

/27./ Эмийн сангийн ажиллагсад жилд 1 удаа нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамрагдана. Учир нь ажиллагсад нь халдварт өвчнөөр өвчилсөн, салст үрэвссэн, идээт үрэвсэлтэй байж болохгүй.

/28./ Үйлдвэрлэгч нь нэг буюу хэд хэдэн бөөний худалдаачид мөн нэг буюу хэд хэдэн жижиглэнгийн худалдаачдаас бүрдэх нэгдсэн тогтолцоонд орно. Энэ нь түгээлтийн ямар суваг вэ?

- A. З түвшингийн суваг
- B. Үйлчилгээний хүрээн дэх суваг
- C. Маркетингийн хэвтээ тогтолцоо
- D. Маркетингийн босоо тогтолцоо
- E. Гэрээт маркетингийн босоо тогтолцоо

/29./ Зах зээлийн хариу үйлчлэлийг идэвхжүүлэх буюу хурдасгахад түлхэц болдог олон янзын хэрэглүүр нь

- A. Борлуулалтын урамшуулал
- B. Ухуулга сурталчилгаа
- C. Зарлал чимэглэл
- D. Үнэ хямдрал
- E. Биечлэн хийх худалдаа

/30./ Хэлэлцэгч талуудын хооронд ямар нэгэн харилцаа тогтоох ба уг харилцааг зохицуулах тухай хэлэлцэн тохиролцсон баримт бичиг нь

- A. Мэдээ
- B. Тодорхойлолт
- C. Илтгэл
- D. Гэрээ
- E. Албан бичиг

/31./ Тодорхой үйл ажиллагааны явцыг дэс дарааллын дагуу нэг бүрчлэн тодорхой тэмдэглэсэн хууль зүйн ач холбогдолтой баримт бичиг нь ямар баримт бичиг вэ?

- A. Протокол
- B. Тайлан
- C. Илтгэх хуудас
- D. Мэдээ
- E. Тушаал

/32./ Бүртгэгдсэн өөрийн нэрээр хэрэглээнд гарч буй эм нь ямар эм болох вэ ?

- A. Женерик эм
- B. Оюуны өмчийн эрхийн хамгаалалтай эм
- C. А ангилалд багтах эм
- D. Оригинал эм
- E. В ангилалд багтах эм

/33./ Эмийн гадаад худалдааны гэрээ байгуулах үед тусгагдаагүй улс төрийн хямрал, эдийн засгийн хориг байгалийн гамшиг гарсанаас болж эмээ авч чадахаа болих нөхцөлийг ямар нөхцөл гэж нэрлэх вэ?

- A. Арбитрын
- B. Урьдчилсан
- C. Форсмажорын
- D. Гэрээнд заагдаагүй
- E. Гэрээний дараах

/34./ Эмийн зах зээл гэдэг нь

- A. Хэрэглэгчдийн зах зээл
- B. Зах зээл дэх эмийг судлах ухаан
- C. Эм үйлдвэрлэл ба борлуулалтын үйл ажиллагаа
- D. Эрэлт хэрэгцээг солилцооны хүрээнд хангах үйл ажиллагаа
- E. Эм эмнэлгийн хэрэгслийг хэрэглэгчид болон цаашид хэрэглэх хэрэглэгчдийн нийлбэр

/35./ Хэрэглэгчдийн хэрэгцээтэй цагт хэрэгцээт газар барааг ойртуулан хүргэхийн тулд пүүсүүд барааны хадгалах тээвэрлэлт болон барааг ойртуулах ажлыг зохион байгуулдаг. Үүнийг

- A. Барааны хөдөлгөөн
- B. Барааны эргэлт
- C. Зах зээл

- D. Барааны түгээлт
- E. Барааны нийлүүлэлт гэнэ.

/36./ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зориулан хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар ирсэн эм, эмнэлгийн хэрэгсэлийн мэдээний нэгдсэн сантай байна.

- A. Монгол Эм импекс концерн
- B. Эрүүл мэндийн улсын хяналтын алба
- C. Эрүүл Мэндийн Спортын Яам
- D. Эрүүл мэндийн газар
- E. Гаалийн ерөнхий газар

/37./ Эмийн чанар муугаас дараах сөрөг үр дагавар гарна.

- 1. Эм хүч чадлаа алдана
- 2. Эм хорт бүтээгдхүүн болж задарна.
- 3. Эмчилгээний үр дүн муу байна
- 4. Эмийн идэвхт бодисын тун буруу байна
- 5. Эмийн стандартын шаардлага зөрчигдөнө.

/38./ Зах зээлийн үед эмийн борлуулалтанд нөлөөлөх хүчин зүйлүүд

- 1. Хүн ам зүйн хүчин зүйл
- 2. Эдийн засаг болон улс төрийн хүчин зүйл
- 3. Шинжлэх ухаан техникийн хүчин зүйл
- 4. Нийгэм соёлын хүчин зүйл
- 5. Орлогын хүчин зүйл

/39./ Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар ирж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл нь дараах шаардлагуудыг хангасан байна.

- 1. Эм үйлдвэрлэгчийн загвар дээж биш байх
- 2. Эмнэлгийн хэрэгсэл нь олон улсын стандартын шаардлага хангасан байх
- 3. GMP-ийн шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэгдсэн байх
- 4. Шошго нь орос, англи, монгол хэл дээр байх
- 5. Мансууруулах, сэтгэц нөлөөт эм нь улсын бүртгэлтэй байх

/40./ Эмийн агуулахын зохион байгуулалтанд ямар шаардлагууд тавигдах вэ?

- 1. Агуулахын хэмжээ багтаамж
- 2. Хүн хүч
- 3. Техник технологийн хүчин чадал
- 4. Захиалалт, нийлүүлэлт
- 5. Татан авалт, хяналт

/41./ Маркетингийн иж бүрэн арга хэмжээ гэж юуг хэлэх вэ ?

- 1. Ашиг орлого олох боломж
- 2. Үнийг нэг түвшинд барих бодлого
- 3. Үйлдвэрлэлийг өсгөх бүх талын бололцоо
- 4. Барааны эрэлтэнд нөлөө үзүүлэх
- 5. Хувиарлалтыг боловсронгуй болгох

/42./ Эмийн мэргэжилтнүүд нь юуны өмнө өвчтөнийг хүндэтгэн үзэж тэдний аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах үүрэгтэй. Яагаад гэвэл эмийн мэргэжилтнүүд нь тангараг өргөнө.

/43./ Эмийн мэргэжилтнүүд нь тасралтгүй сургалтын хөтөлбөрийн дагуу мэргэжил мэдлэгээ байнга дээшлүүлж ажиллах ёстой. Үүнийг эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээнд заасан.

/44./ Эмийн мэргэжилтнүүд нь ёс зүйн зарчмыг хүлээн зөвшөөрч ажиллах ёстой. Эмийн санчдын ёс зүй нь тэднээс эелдэг даруу, хүнлэг нинжин сэтгэлтэй, үнэнч шударга байхыг шаардана.

/45./ Контракцийн үзэгдэл гэж юуг хэлэх вэ?

- A. Этанолыг усаар шингэлэхэд дулаан шингээж холимогийн температур багасч эзэлхүүн нь нэмэгддэг бөгөөд үүнийг контракцийн үзэгдэл гэнэ.
- B. Этанолыг усаар шингэлэхэд холимогийн температур багасч эзэлхүүн нь ихэсдэг бөгөөд үүнийг контракцийн үзэгдэл гэнэ.
- C. Этанолыг усаар шингэлэхэд дулаан үүсч холимогийн температур ихэсч эзэлхүүн нь багасдаг бөгөөд үүнийг контракцийн үзэгдэл гэнэ.
- D. Этанолыг усаар шингэлэхэд дулаан үүсч холимогийн температур ихэсч эзэлхүүн нь мөн ихэсдэг бөгөөд үүнийг контракцийн үзэгдэл гэнэ.
- E. Этанолыг усаар шингэлэхэд холимогийн температур багасч эзэлхүүн нь багасдаг бөгөөд үүнийг контракцийн үзэгдэл гэнэ.

- /46./ Бэлтгэсэн уусмалын концентраци багадсан бол нэмэх хуурай бодисынхэмжээг дараах томъёогоор олно
- A. $X = a - (b \cdot c) / 100(d - b)$
 - B. $X = a(c - b) / b$
 - C. $X = a(b - c) / 100d - b$
 - D. $X = a(c - b) / b - c$
 - E. $X = a(c - b) / 100d - b$
- /47./ Ууранд хамгийн түрүүнд ямар бодисыг нунтагладаг вэ?
- A. Индифферент бодис
 - B. Хортой бодис
 - C. Тритураци
 - D. Будагтай бодис
 - E. Хөнгөн бургимтгай бодис
- /48./ Жоронд спиртэн уусмалын концентрацыг заагаагүй бол хэдэн процентоос авч бэлтгэх вэ?
- A. 70 хувь
 - B. 95 хувь
 - C. 90 хувь
 - D. 30 хувь
 - E. 50 хувь
- /49./ Тосон түрхэцийн фармакологийн үйлдэл нь юугаар тодорхойлогддог вэ?
- A. Эмийн бодисын химийн шинж чанараар
 - B. Үйлчлэгч бодисын концентрацаар
 - C. Туслах бодисын шинж чанараар
 - D. Технологийн бодисын шинж чанараар
 - E. Бүх л эмзүйн хүчин зүйлүүдийн комплексоор
- /50./ Фурациллины уусах онцлогийг сонгоно уу?
- A. Усны гадаргуу дээр цацаад хөдлөхгүй хутгана
 - B. Устай жижиглэнэ
 - C. Халааж уусгана
 - D. Хөвмөл байдлаар буцалж буй ус руу хийнэ
 - E. Хүчиллэгжүүлсэн усанд уусгана
- /51./ Уур нүдүүрийн хэмжээг яаж сонгох вэ?
- A. Тугналтаас
 - B. Нунтагийн масс нь уур нүдүүрийн багтаамжийн 1/20 хэтрэхгүй байх ёстой
 - C. Томъёо ашиглаж тооцно.
 - D. Баримжаагаар сонгож авна
 - E. Энгийн нүдээр харж сонгоно.
- /52./ Тосон түрхэцийн найрлаганд дэгдэмхий бодис болох ментол, кампор, тимол, фенол зэрэг бодис орсон байвал сууриндаа яаж оруулах вэ?
- A. Сууриа халааж хайлуулаад нэмнэ
 - B. Сууриндаа шууд нэмж хийгээд сайтар хутгана
 - C. Хайлуулж хагас хөргөсөн сууриндаа уусгана
 - D. Эмийн бодисоо усанд уусгаж уусмал байдалдоруулаад нэмнэ
 - E. Эмийн бодисоо спиртэнд уусгана
- /53./ Өтгөн экстракттай нунтгийг бэлтгэхэд юуг анхаарах вэ?
- A. Тунг маш нарийн хэмжиж авах
 - B. Гар жингийн таваг уур нүдүүрийг бохирдуулахгүй байхыг
 - C. Эхэлж авч ууранд хийх
 - D. Заавал аналитик жин дээр хэмжих
 - E. Асгахгүй байх
- /54./ Хайлш хэлбэрийн тосон түрхэц бэлтгэхдээ ямар бодисоос эхлэж хайлуулдаг вэ?
- A. Эмийн бодис
 - B. Суурь бодисыг
 - C. Өндөр температурт хайлдаг суурь бодисыг
 - D. Амархан уусдаг бодис
 - E. Уусдаггүй бодисыг
- /55./ Жинхэнэ уусмалын шинж чанарыг нэрлэнэ үү?
1. Гадна байдал нь тунгалаг
 2. Жижиг хэсгүүд нь ультра шүүлтүүрээр нэвтэрнэ
 3. Жижиг хэсгүүд нь цаасан шүүлтүүрээр нэвтэрнэ
 4. Тогтвор сайтай
 5. Ердийн микроскопанд харагдана

/56./ Бодисыг нунтаглаж хэмжээг нь багасгахад ямар давуу талууд бий болдог вэ?

1. Шимэгдэх хурд сайжирна
2. Сорбцын бүх төрлүүд ихэснэ
3. Тунг багасгах боломжтой
4. Хатуу фазуудын харилцан үйлчлэл суларна
5. Шархнаас ялгарч байгаа шингэнийг шингээх чадвар муудна

/57./ Үрэл эм үйлдвэрлэхэд ордог туслах бодисуудыг сонго.

1. Сахар
2. Цардуул
3. Тальк
4. Шоколад
5. Хүнсний будаг

/58./ Идээшмэл бэлтгэхдээ

1. Усан халаагуур дээр 15 минут халаана
2. 3,3 л хүртэл хэмжээтэй бол усан халаагуур дээр 25 минут халаана
3. Тасалгааны температурт 45 минут хөргөнө
4. Усан халаагуур дээр 30 минут халаана
5. Тасалгааны температурт 10 минут хөргөнө

/59./ Тосон түрхэцээс эмийн бодис шимэгдэх процессыг сайжруулах сууринд ямар суурь хамаарагддаг вэ?

1. Вазелин
2. Ланолин ургамалын тостой холимог
3. Сликнон суурь
4. Константны эмульсэн суурь ус/вазелин
5. Загасан тос

/60./ Амархан исэлддэг бодисын уусмалыг бэлтгэхдээ:

1. Шууд олгох шилэнд бэлтгэнэ
2. Шилэн шүүлтүүрээр шүүнэ
3. Халуун нэрмэл усаар сайтар зайлсан хөвөнгөөр шүүнэ
4. Шүүлтийн цаас хэрэглэхгүй
5. Шүүлгүйгээр олгоно

/61./ Зуурамтгай шинж чанартай уусгагч бүхий уусмалыг бэлтгэх ямар онцлог байдаг вэ?

1. Жингийн аргаар бэлтгэх
2. Ариутгасан хуурай олгох шилэнд халаах замаар уусгана
3. Шаардлагатай бол хоёр давхар самбайгаар шүүнэ
4. Жин-эзэлхүүний аргаар бэлтгэх
5. Халаах шаардлага гардаг учир хуурай шилэнд уусгана

/62./ Ургамалын түүхий эдээс үйлчлэгч бодисыг бүрэн гүйцэд хандлахад юу нөлөөлдөг вэ?

1. Түүхий эд экстрагентын харьцаа
2. Диффузын процессын хурд
3. Хандлах дэглэм
4. Усан ялгамалын эзэлхүүн
5. Экстракт-концентрацын эзэлхүүн

/63./ Стандарт фармакопейн III бүлгийн шингэнүүд

1. Формальдегидийн уусмал
2. Устөрөгчийн хэт испийн уусмал
3. Буравын шингэн
4. Сулруулахдаа стандарт фармакопейн шингэнийг 100% цэвэр бодис гэж тооцно
5. Сулруулалтын томьёо ашиглана

/64./ Фармакопей гэдэг нь эмийн зүйлүүд, эмийн хэлбэрүүдийн чанарын хэм хэмжээг тогтоосон стандарт заавруудын эмхэтгэл юм. Ийм учраас фармакопейд ямар ч мадаггүй болтлоо шалгагдсан зүйлүүдийг түүвэрлэн бичих бөгөөд сурах бичиг биш харин хуулийн хүчинтэй гарын авлага юм.

/65./ Үр жимсийн жижиглэлтийн хэмжээг заана уу?

- A. 0,3-0,5 мм
- B. 0,5-2,0 мм
- C. 1-3 мм
- D. 3-5 мм
- E. 0,5-1 мм

/66./ Хандлалтад нөлөөлөх хүчин зүйлийн гадаргуугийн талбай хандлалтад яаж нөлөөлөл үзүүлэх вэ?

- A. Шууд
- B. Урвуу
- C. Нөлөөлөхгүй
- D. Аль нь ч биш
- E. Бүгд

/67./ Этилийн спирт амьтны гаралтай ямар түүхий эдийг даршлахад илүү тохиромжтой вэ?

- A. Өнчин тархи
- B. Нойр булчирхай
- C. Бамбай булчирхай
- D. Өндгөвч
- E. Элэг

/68./ Ялгамал гаргаж авах хэсэгчилсэн мацерацын аргын онцлог юу вэ?

- A. Түүхий эд, экстрагентыг 4 хувааж хандлана.
- B. Түүхий эдийг 2 хувааж экстрагентыг хуваахгүйгээр хийж хандлалтыг явуулна.
- C. Экстрагентыг 2 хувааж, эхний удаад түүхий эдээс 4-6 дахин их хэмжээний экстаргентаар 6-12 цаг хандлана, үлдэгдлийг 3-4 дахин их хэмжээний экстрагентаар 4-6 цаг хандлаад, ялгамлуудыг нийлүүлнэ
- D. Түүхий эд, экстрагентыг 8 хувааж хандлана
- E. Экстрагентыг хуваахгүйгээр 6-12 цаг хандлана.

/69./ Тиреодиний бэлдмэлийг ямар түүхий эдээс гаргах вэ?

- A. Бөөрний дээд булчирхай
- B. Өнчин тархи
- C. Төмсөг
- D. Нойр булчирхай
- E. Бамбай булчирхай

/70./ Галены бэлдмэлүүд нь ямар бодис агуулсан бэлдмэлүүд вэ?

- A. Химийн цэвэр бодис агуулсан бэлдмэл
- B. Биологийн идэвхт бодисуудыг нийлмэл байдлаар агуулсан бэлдмэл
- C. Ургамал, амьтны гаралтай түүхий эдэд агуулагдах биологийн идэвхт бодисуудыг дагалдах бодисуудын хамтаар нийлмэл байдлаар агуулсан бэлдмэл
- D. Ургамал амьтны гаралтай түүхий эдэд агуулагдах бодисуудыг комплексоор нь агуулсан бэлдмэл
- E. Биологийн идэвхт бодис дангаар нь агуулсан бэлдмэл

/71./ Дараах хандлагчдаас аль нь зуурамтгай чанар ихтэй вэ?

- A. Этилийн спирт
- B. Нэрмэл ус
- C. Глицерин
- D. Нүүрстөрөгчийн диоксид
- E. Наранцэцэгийн тос

/72./ Түүхий эдийн нүхлэг шинж чанарын тодорхойлолтыг заана уу?

- A. Хандлагчийг өөртөө шингээх чадвар
- B. Түүхий эдийн доторх эвдэрсэн эсийн зэрэг
- C. Ургамлын түүхий эд доторх хоосон зай
- D. Жижиглэсэн материалын жижиг хэсгүүдийн хоорондох зай
- E. Түүхий эдийн сиймхий ба нүхлэг шинж чанараас хамаарсан үзүүлэлт

/73./ Хуурай хандны чанарыг ямар шалгуураар шалгадаг вэ?

1. Чийглэг
2. Хүнд металлын хэмжээ
3. Үйлчлэгч бодисын хэмжээ
4. Ялгамалын нягт
5. Ялгамалын савлагаа

/74./ Хандмалуудыг мэдрэхүйн эрхтэний тусламжтайгаар шалгаж үзэхэд ямар шаардлага хангаж байх ёстой вэ?

1. Ургамлын түүхий эдэд агуулагдаж байгаа бодисын үнэр, амтыг хадгалсан байх
2. Нэг төрлийн байдал
3. Тунгалаг байх
4. Спиртийн амттай байх
5. Гашуун амттай байх

/75./ Түүхий эдийг хэт жижиглэхэд ямар муу талууд илрэх вэ?

1. Хандлагч шингэний нэвтрэн орох процесс муудна
2. Гарган авсан ялгамал булингартана
3. Хандлах процесс удааширна

4. Түүхий эдийн экстрагенттэй хүрэлцэх талбай ихэснэ
5. Түүхий эдийн технологийн шинж чанар сайжирна

/76./ Ургамалын түүхий эдийг хандлахын өмнө жижиглэх шаардлагатай. Учир нь гадаргуугийн талбай ихэссэнээр хандлагчтай хүрэлцэх талбай нэмэгдэнэ.

/77./ Түүхий эдийг хэт жижиглэх нь хандлалтад сайнаар нөлөөлнө. Учир нь хэт жижиглэхэд хандлагч шингэний түүхий эдэд нэвчин орох чадвар нэмэгдэнэ.

/78./ Тусгайлсан заалт байхгүй бол бүрхүүлгүй шахмал ямар хугацаанд задрах вэ?

- A. 30 мин –аас ихгүй
- B. 10 мин –аас ихгүй
- C. 15 мин –аас ихгүй
- D. 5 мин –аас ихгүй
- E. 3 мин –аас ихгүй

/79./ Бактерцидны лампыг ажил эхлэхээс хэдэн цагийн өмнө ажиллуулах вэ?

- A. 1-2
- B. 3-4
- C. 2-4
- D. 2-3
- E. 4-6

/80./ Туншилний бүрэн байдлыг шалгахдаа ямар уусмалд шалгах вэ?

- A. Спиртийн уусмалд
- B. Хлорамины уусмалд
- C. Нэрмэл усанд
- D. Метилен хөхийн уусмалд
- E. Фурациллины уусмалд

/81./ Үйлдвэрийн ердийн гэрэлтүүлэг хэд вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. 450 люкс
- B. 350 люкс
- C. 300 люкс
- D. 265 люкс
- E. 500 люкс

/82./ Хэрэв тусгайлан заалт байхгүй бол бүрхүүлтэй шахмал эм ямар хугацаанд задрах вэ?

- A. 15 мин-аас ихгүй
- B. 30 мин-аас ихгүй
- C. 5 мин-аас ихгүй
- D. 10 мин-аас ихгүй
- E. 3 мин-аас ихгүй

/83./ Хатуу болон зөөлөн капсулыг ямар аргаар гарган авдаг вэ?

1. Дүрэх арга
2. Дуслын арга
3. Хэвлэх
4. Хөөлгөх
5. Өнхрүүлэх

/84./ Шигших процесст нөлөөлөх хүчин зүйлүүд юу вэ?

1. Шигшүүрийн нүхний хэлбэр хэмжээ
2. Шигшигдэж байгаа материалын үений зузаан
3. Шигшигдэж байгаа материалын чийглэг
4. Шигшигдэж байгаа материалын хөдөлгөөний хурд
5. Шигшүүрийн хөдөлгөөний чиглэл

/85./ Шахмал эмийн хэлбэрийн давуу талд аль хамаарах вэ?

1. Хадгалах явцад задралт нь удааширдаг
2. Хадгалах явцад хатуурч цемент шиг болдог
3. Бүх өвчтөнгүүд хэрэглэж болдоггүй
4. Нарийн тунлагдсан
5. Концентрацитай уусмал үүсч салстыг цочроодог

/86./ Үйлдвэрлэлийн байрыг ямар ямар бүс болгон хувааж үздэг вэ?

1. Цагаан бүс
2. Саарал бүс
3. Хар бүс
4. Ногоон бүс

5. Цэнхэр бүс

/87./ Нэгэн жигд ширхэгтэй элсэн чихрийн ширхэгээр үрлийн цөмийг бэлтгэдэг. Учир нь жигд бус ширхэгтэй сахах авбал үрлийн цөм бэлтгэх явцад хэлбэр, дүрс, хэмжээ нь өөрчлөгдөж үрлийн чанарт муугаар нөлөөлдөг.

/88./ Эмийн бодисын уусалтыг ГФ.XI -ийн дагуу тодорхойлоход 1гр бодисыг 15мл өгөгдсөн уусгагчдад хийж 18-220С-ийн хэмд сэгсэрэхэд 10 минутанд уусч байвал уусалт нь ямар бодис гэх вэ?

- A. Хялбар
- B. Маш хялбар
- C. Уусдаг
- D. Муу уусдаг
- E. Маш муу уусдаг

/89./ Үл мэдэгдэх эмийн бодис руу мөнгөний нитрат нэмэхэд цагаан тунадас үүсэв. Ямар анион байсан бэ?

- A. Ацетат
- B. Хлорид
- C. Иодид
- D. Сульфат
- E. Бромид

/90./ Натрийн карбонатын уусмалыг натрийн гидрокарбонатын уусмалаас хэрхэн ялгах вэ?

- A. Лакмусын индикатор
- B. Фенолфталеины индикатор
- C. Метил улаан индикатор
- D. Цууны хүчилтэй явагдах урвалаар
- E. Эрдэс хүчилтэй явагдах урвалаар

/91./ Нэрмэл усны орчинг сонго.

- A. PH 3,0-4,3
- B. PH 5,4 - 7,5
- C. PH 5,0-6,8
- D. PH 6.5-7.0
- E. PH 7.0-7.5

/92./ Цайр, кальци, магнийн тооны тодорхойлолтыг ямар аргаар хийх вэ?

- A. Роданометр
- B. Комплексонометр
- C. Тунадасжуулах
- D. Саармагжуулах
- E. Меркуриметр

/93./ Натрийн бромидын тооны тодорхойлолтыг хийхэд дараах аргуудын алийг нь сонгох вэ?

- A. Иодомер
- B. Комплексонометр
- C. Аргентометр
- D. Саармагжуулах
- E. Нитритометр

/94./ Анальгины тооны тодорхойлолт аль нь вэ?

- A. Аргентометр
- B. Иодомер
- C. Перманганатометр
- D. Нитритометр
- E. Алкалиметр

/95./ Урвуу титрлэлт гэж юу вэ?

A. Тодорхойлох бодистой ажлын уусмалыг шууд хийх.
B. Тодорхойлох бодисыг ямар нэгэн урвалж бодистой урвалд оруулж бүтээгдэхүүнийг ажлын уусмалаар титрлэх.

C. Тодорхойлох бодисыг ямар нэгэн урвалж бодистой урвалд оруулж илүүдлийг титрлэнэ.

D. Тодорхойлох бодис руу мэдэгдэж буй концентрацитай уусмалыг илүүдлээр нэмж үлдэгдэлийг нь ажлын уусмалаар титрлэнэ

E. Тодорхойлох бодис руу ямар нэгэн концентрацитай уусмалыг илүүдлээр нэмж үлдэгдэлийг нь ажлын уусмалаар титрлэнэ

/96./ Нэрмэл ус саармаг орчинтой байх ёстой. Үүнийг тодорхойлоход дараах индикаторуудын алийг нь сонгох вэ?

- A. Фенолфталеин

- B. Метил улаан
- C. Метил хөх
- D. Метил улбар
- E. Тропеолон-оо

/97./ Титрийн уусмалыг яаж бэлтгэх вэ?

- 1. Концентрацитай уусмалаас
- 2. Химийн цэвэр бодисоос фармакопейн дагуу
- 3. Сулруулсан уусмалаас
- 4. Фиксаналаас
- 5. Уусмалаас

/98./ Дараах эмүүдээс аль нь усанд уусдаггүйг нэрлэнэ үү?

- 1. Адреналины гидрохлорид
- 2. Скопаламины гидробромид
- 3. Гоматропины гидробромид
- 4. Барийн сульфат
- 5. Морфины гидрохлорид

/99./ Усанд аль эм хялбар уусдаг вэ?

- 1. Фенилсалицилат
- 2. Ацетилсалицилийн хүчил
- 3. Тимол
- 4. Новокайн
- 5. Резорцин

/100./ Сулруулсан давсны хүчлийн уусмалыг дараах заалтын алинд нь хэрэглэдэггүй вэ?

- 1. Ходоодны хүчил багадсан үед
- 2. Цус багадалтанд төмрийн бэлдмэлийг хэрэглэх үед
- 3. Хоолны шингэц муудсан үед пепсинтэй холимог шингэнээр
- 4. Ходоодны хүчил ихэдсэн үед
- 5. Төмрийн бэлдмэл хэрэглэх үед

/101./ Этилийн спиртийн градусыг хэмжих багаж аль нь вэ?

- 1. Термометр
- 2. Спиртомер
- 3. Рефрактометр
- 4. Денсиметр
- 5. Поляриметр

/102./ Морын арга гэдэг нь мөнгөний ион, хлорын ионы хооронд явагдах урвал дээр үндэслэгдсэн арга . Учир нь титрийн уусмал нь 0,1N мөнгөний нитрат.

/103./ Аскорбины хүчлийн уусмалыг тогтворжуулахын тулд натрийн метагидросульфат эсвэл натрийн сульфат тулд нэмж өгнө. Учир нь аскорбины хүчил агаар металл, хүчил шүлтийн нөлөөгөөр амархан исэлддэг.

/104./ Эмийн багваахайн эмчилгээний үйлдлийг сонго.

- A. Даралт бууруулах
- B. Цус тогтоох
- C. Шээс хөөх
- D. Үрэвслийн эсрэг
- E. Хоол боловсруулах эрхтний үйл ажиллагааны хямрал

/105./ Гүүний саамны эмнэлэг биологийн ач холбогдол

- A. Мэдрэлийн өвчин
- B. Элэгний хорыг арилгах
- C. Нойргүйдэх өвчин
- D. Бөөрний үйл ажиллагаа сайжруулах
- E. Үе мөчний өвчний үед өвдөлт намдаах

/106./ Ямар зүрхнийг ликозид нь биед хуримтлагдан хортой нөлөө үзүүлэх нь бага байдаг вэ?

- A. Улаан хуруувчин цэцэг
- B. Май цэцэг
- C. Том цэцэгт хуруувчин цэцэг
- D. Хаврын алтан хундага
- E. Үсэрхэг хуруувчин цэцэг

/107./ Чихэр өвсний ямар түүхий эдийг хэрэглэх вэ?

- A. Өвс

- В. Үр жимс
- С. Үндэс
- Д. Цэцэг
- Е. Өвс

/108./ Алкалоидуудын гүйцэтгэх үүрэг нь?

- 1. Фотосинтезийн процесст зайлшгүй шаардлагатай
- 2. Өсөлт хөгжлийг сайжруулах
- 3. Ургамлыг эрүүлжүүлэх
- 4. Нөхөн төлжүүлэх
- 5. Амьсгалах

/109./ Органик нэгдлүүдэд юу юу хамаарах вэ?

- 1. Нүүрс ус
- 2. Сахар
- 3. Амин хүчил
- 4. Ус
- 5. Микроэлемент

/110./ Нохойн хошууны жимсийг 20°35°С хатаана. Нохойн хошуунд эфирийн тос агуулагдана.

/111./ Хүн орхоодойн үндэсний ханд нь хөөсрүүлэх урвал өгнө. Учир нь үндсэнд нь тритерпений сапонин агуулагдана.

/112./ Үхэр мэхээрийн химийн бүрэлдэхүүн

- А. Эфирийн тос
- В. Флаванойд
- С. Аргаах бодис
- Д. Салс
- Е. Аскорбины хүчил

/113./ Тосонд уусдаг витаминыг нэрлэ.

- А. А, D, E, K
- В. С, P, PP, B
- С. PP, B, A, D,
- Д. С, P, E, K
- Е. P, PP, A, B

/114./ Эмийн бэлдмэл гэж юу вэ?

- А. Эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэдэг химийн өвөрмөц нэгдэл юм.
- В. Эмчилгээний буюу урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагатай үр нөлөө гаргахын тулд эмийн зүйлийг хэрэглэхэд тохиромжтой хэлбэрт оруулсаныг хэлнэ.
- С. Эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх нэг буюу хэд хэдэн эмийн бодисыг хэлнэ.
- Д. Эмийн зүйлийг тодорхой хэлбэрт оруулж тугнасаныг эмийн бэлдмэл гэнэ
- Е. Хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, дархлаажуулах зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэл зүйн сорилт туршилтаар нотлогдсон нийлэг буюу амьтан, ургамал, эрдсийн гаралтай бодисыг тодорой хэлбэрт оруулсан, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг бэлдмэл.

/115./ Фармакокинетик гэж юу вэ?

- А. Эмийн бодисын бие махбодод шимэгдэх, тархах, хувирах үйл явц юм.
- В. Эмийн бодисын бие махбодод шимэгдэх, тархах, хувирах өөрчлөгдөх, ялгаран гарах үйл явц юм.
- С. Эмийн бодисын бие махбодиос ялгаран гарах үйл явц юм.
- Д. Эмийн бодисын бие махбодид өөрчлөгдөх үйл явц юм.
- Е. Эмийн бодисын бие махбодид тархах үйл явц юм.

/116./ Эмчилгээний тун гэж юу вэ?

- А. Бие махбодид эмчилгээний зайлшгүй үр нөлөө үзүүлж чадах эмийн бодисын хэмжээг эмчилгээний тун гэнэ.
- В. Бие махбодид эмчилгээний үр нөлөө үзүүлхүйц эмийн бодисын хэмжээг эмчилгээний тун гэнэ
- С. Бие махбодид эмчилгээний үр нөлөө үзүүлэх магадлалтай эмийн бодисын хэмжээг эмчилгээний тун гэнэ
- Д. Бие махбодид эмчилгээний үр нөлөө үзүүлэх боломжтой эмийн бодисын хэмжээг эмчилгээний тун гэнэ
- Е. Бие махбодид үйлдэл үзүүлж чадах эмийн бодисын хэмжээг эмчилгээний тун гэнэ.

/117./ Бромгексин аль бүлгийн эм бэ?

- A. Ханиалга намдаах
- B. Цэр шингэлэх
- C. Цэр ховхлох
- D. Амьсгал сэргээх
- E. Өвдөлт намдаах

/118./ Эмийн бодис гэж юу вэ?

- A. Эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэдэг химийн өвөрмөц нэгдэл юм.
- B. Эмчилгээний буюу урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагатай үр нөлөө гаргахын тулд эмийн зүйлийг хэрэглэхэд тохиромжтой хэлбэрт оруулсаныг хэлнэ.
- C. Эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх нэг буюу хэд хэдэн эмийн бодисыг хэлнэ.
- D. Эмийн зүйлийг тодорхой хэлбэрт оруулж тугнасаныг эмийн бэлдмэл гэнэ
- E. Хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, дархлаажуулах зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэл зүйн сорилт туршилтаар нотлогдсон нийлэг буюу амьтан, ургамал, эрдсийн гаралтай бодисыг тодорой хэлбэрт оруулсан, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг бэлдмэл.

/119./ Бөөлжилтийн эсрэг эмийг сонгоно уу

- A. Гордокс
- B. Мезим-Форте
- C. Эссенциал
- D. Церукал
- E. Фенамин

/120./ Эмийн тун гэж юу вэ?

- A. Эмийн бодисын хэрэглэх хэмжээг тун гэнэ.
- B. Эмийн бодисын нэгжийг тун гэнэ.
- C. Бие махбодид жин, эзэлхүүн, үйлдлийн нэгжээр хэмжиж оруулах эмийн бодисын үйлдэлийг тун гэнэ.
- D. Бие махбодид оруулах эмийн бодисын хэмжээг эмийн тун гэнэ
- E. Бие махбодид жин, эзэлхүүн, үйлдлийн нэгжээр хэмжиж оруулах эмийн бодисын хэмжээг эмийн тун гэнэ.

/121./ Эмийн үйлдэл гэж юу вэ?

- A. Хүний болон мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зорилгоор зохист тунгаар хэрэглэхэд бие махбодид гарч болзошгүй болон гарч байгаа сөрөг илрэл.
- B. Эм нь бие махбодид үйлчилж үйл ажиллагааг түр зуур өөрчлөхийг хэлнэ.
- C. Эмийн бэлдмэл хэрэглэхэд бие махбодитой харилцан үйлчлэлийн үр дүн
- D. Хүний болон мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зорилгоор зохист тунгаар хэрэглэхэд бие махбодид тогтмол гардаг сөрөг илрэл.
- E. Хүний болон мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлоход бие махбодид гарч болзошгүй болон гарч байгаа сөрөг илрэл.

/122./ Элэг хамгаалах эмийг сонгоно уу.

- A. Гордокс
- B. Мезим-Форте
- C. Эссенциал
- D. Церукал
- E. Фенамин

/123./ Тальк, идэвхижүүлсэн нүүрс зэрэг нь аль эмийн бүлэгт хамаарах вэ?

- A. Хэсгийг мэдээгүйжүүлэх эм
- B. Аргаах эм
- C. Шингээх эм
- D. Бүрхээх эм
- E. Татах эм

/124./ Эмэнд тавигдах шаардлагыг сонгоно уу

1. Үр дүнтэй
2. Аюулгүй
3. Хүртээмжтэй
4. Хэрэглэхэд хялбар
5. Сонголттой

/125./ Ходоодны булчирхайн шүүрэл ихэссэн үед хэрэглэх эмийг хэд ангилах вэ?

1. Ходоодны булчирхайн шүүрлийг багасгах эм
2. Ходоодны хүчил саармагжуулах эм
3. Ходоод хамгаалах эм

4. Ходоодны шүүрлийг нэмэгдүүлэх эм
 5. Ходоодны булчинг сулруулах эм
- /126./ Эмийн эмчилгээний тунг хэрхэн ангилах вэ?
1. Эмчилгээний бага тун
 2. Эмчилгээний дунд тун
 3. Эмчилгээний дээд тун
 4. Эмчилгээний доод тун
 5. Эмчилгээний харьцангуй тун
- /127./ Эмийн үйлдэл юунаас хамаарах вэ?
1. Нас
 2. Хүйс
 3. Удамшлын хүчин зүйл
 4. Бие махбодийн байдал
 5. Хоногийн хэмнэл
- /128./ Эмийн бодисыг хоол боловсруулах бус замаар оруулах аргуудыг сонгоно уу.
1. Уух арга
 2. Тарих арга
 3. Шулуун гэдсэнд хийх
 4. Амьсгалын замаар оруулах
 5. Хэлэн дор тавьж шимэх
- /129./ Ханиалга намдаах эмийг үйлдэлийн чиглэлээр хэрхэн ангилах вэ?
1. Наркозын үйлдэлтэй
 2. Төвийн үйлдэлтэй
 3. Наркозын бус үйлдэлтэй
 4. Захын үйлдэлтэй
 5. Ерөнхий үйлдэлтэй
- /130./ Усанд уусдаг витаминуудыг сонгоно уу.
1. Ретинол
 2. Тиамин
 3. Токоферол
 4. Никотины хүчил
 5. Эргокальциферол
- /131./ Ходоод хамгаалах зорилгоор Сукральфатыг хэрэглэнэ. Учир нь шархлааны үхжсэн эдийн уурагтай харилцан үйлчилж өнгөр үүсгэнэ.
- /132./ Церукалын олон улсын нэршил нь Metoclopramide бөгөөд янз бүрийн шалтгаантай бөөлжилтийн эсрэг үйлдэл үзүүлнэ.
- /133./ Эргокальциферол нь нарны хэт ягаан туяаны нөлөөгөөр арьсанд үүсдэг. Яагаад гэвэл ретинол нь мукополисахаридын нийлэгжилтэнд оролцоно
- /134./ Бензилпенициллин гаж нөлөө
- A. Чонон хөрвөс, анафлаксын шок
 - B. Чих дүлийрэх
 - C. Квинкийн хаван, таргалалт
 - D. Шүд шарлах
 - E. Анафлаксийн шок, шарлалт
- /135./ Клиникийн фармакодинамик гэж юу вэ?
- A. Бие махбодийн харилцан үйлчлэлийн дүнд илрэх хариу урвалыг ерөнхийд нь фармакодинамик гэнэ.
 - B. Эмийн бодис ба бие махбодийн харилцан үйлчлэлийн дүнд илрэх хариу урвалыг ерөнхийд нь фармакодинамик гэнэ.
 - C. Эмийн бодисын харилцан үйлчлэлийн дүнд илрэх хариу урвалыг ерөнхийд нь фармакодинамик гэнэ.
 - D. Эмийн бодис ба бие махбодийн харилцан үйлчлэлийн дүнд илрэхгүй хариу урвалыг ерөнхийд нь фармакодинамик гэнэ.
 - E. Эмийн бодис ба бие махбодийн харилцан үйлчлэлийн дүнд илэрч болох хариу урвалыг ерөнхийд нь фармакодинамик гэнэ.
- /136./ Ацидоз гэж юуг хэлэх вэ?
- A. Шүлтлэг зүйл биед хуримтлагдахыг хэлнэ
 - B. Хүчиллэг, шүлтлэг аль аль хуримтлагдахыг хэлнэ

- C. Төрөл бүрийн эмгэгийн үед хүчиллэг хуримтлагдахыг хэлнэ
D. Бие организмд бодисын солилцооны эцсийн бүтээгдэхүүн хуримтлагдахыг хэлнэ
E. Төрөл бүрийн өвчний үед шүлтлэг хуримтлагдахыг хэлнэ
- /137./ Зүрхний дутагдлын үед ямар эмээр эмчилгээг эхлэх вэ?
A. Судас өргөсгөх эмээр
B. Диуретикээр
C. Инотроп нөлөөт эмээр
D. Артерийн даралт бууруулах эмээр
E. Төвийн үйлдэлтэй эмээр
- /138./ Антибиотик хэрэглэсний улмаас хүүхдийн ясжилт өөрчлөгдөн шүдний өнгө нь шарлажээ. Дараах антибиотикудаас алийг нь хэрэглэж байсан байх вэ?
A. Ампициллин
B. Тетрациклин
C. Гентамицин
D. Левомецетин
E. Цефазолин
- /139./ Гуурсан хоолойн багтрааг эмчлэх эмийн эмчилгээний үндсэн чиглэлийг олно уу?
A. Тамхи татахыг хориглох
B. Бронхийн агшилтыг сулруулах, харшил суурьтай үрэвслийг намдаах
C. Үрэвслийг намдаах
D. Харшлын суурьтай үрэвслийг намдаах
E. Харшлыг намдаах
- /140./ Эмийн гаж нөлөөний шалтгааныг нэрлэнэ үү?
1. Өвчтөн нэг дор олон нэр төрлийн эм хэрэглэх
2. Өвчтөн эмийг зохисгүйгээр дур мэдэн хэрэглэх
3. Эмчийн зааваргүйгээр эм хэрэглэх
4. Биологийн өндөр идэвхтэй эмт бодисын хэрэглээ өссөн
5. Биед үзүүлэх гадаад хүчин зүйлийн нөлөө ихэссэн
- /141./ Бисептолыг хэрэглэж болохгүй цээрлэлийг сонгоно уу?
1. Бөөрний илэрхий өөрчлөлттэй
2. Жирэмсэн үе
3. Элэгний илэрхий өөрчлөлттэй
4. 1 сар хүртэлх насны хүүхэд
5. Түүрүү булчирхайн үрэвсэл
- /142./ Фармакокинетикийн үндсэн ухагдахууныг дурьдана уу?
1. Биохүрэхүй (F)
2. Тархалтын эзэлхүүн (Vd)
3. Элиминаци, клиренс (Cl)
4. Хагас элиминацын хугацаа (t1/2)
5. Уурагтай холбогдолт
- /143./ Хеликобактерийн эсрэг нөлөөт эмүүдийг сонгоно уу?
1. Тетрациклин
2. Амоксациллин
3. Мономицин
4. Метронидазол
5. Ампициллин
- /144./ Каптоприлийн гаж нөлөөг сонгоно уу?
1. Арьсны тууралт
2. Ханиалгах
3. Амтны мэдрэмж өөрчлөгдөх
4. Хамар битүүрэх
5. Зүрх дэлсэх
- /145./ Антибиотик эмчилгээний үр дүнг ямар аргаар хянах вэ?
1. Цусны шинжилгээ
2. Шээсний шинжилгээ
3. Рентген шинжилгээ
4. Өвөрмөц антителийн титр
5. Биеийн температур, хордлогын шинж

Хувилбар 2-р сорилын зөв хариулт

1-B, 2-A, 3-B, 4-D, 5-D, 6-D, 7-A, 8-E, 9-D, 10-A, 11-A, 12-B, 13-D, 14-B, 15-E, 16-D, 17-C, 18-D, 19-A, 20-C, 21-A, 22-E, 23-A, 24-A, 25-C, 26-A, 27-A, 28-D, 29-A, 30-D, 31-A, 32-D, 33-C, 34-E, 35-A, 36-C, 37-B, 38-E, 39-B, 40-E, 41-D, 42-C, 43-A, 44-A, 45-C, 46-C, 47-A, 48-C, 49-E, 50-C, 51-B, 52-C, 53-B, 54-C, 55-B, 56-A, 57-E, 58-A, 59-C, 60-A, 61-E, 62-A, 63-E, 64-A, 65-A, 66-A, 67-D, 68-C, 69-E, 70-C, 71-C, 72-C, 73-A, 74-B, 75-A, 76-A, 77-E, 78-C, 79-A, 80-D, 81-C, 82-B, 83-A, 84-E, 85-D, 86-A, 87-A, 88-C, 89-B, 90-B, 91-C, 92-B, 93-C, 94-B, 95-D, 96-B, 97-C, 98-D, 99-D, 100-D, 101-C, 102-A, 103-A, 104-E, 105-B, 106-D, 107-C, 108-E, 109-A, 110-E, 111-A, 112-C, 113-A, 114-D, 115-B, 116-A, 117-B, 118-A, 119-D, 120-E, 121-C, 122-C, 123-C, 124-B, 125-B, 126-A, 127-E, 128-C, 129-C, 130-C, 131-A, 132-A, 133-B, 134-E, 135-B, 136-B, 137-B, 138-B, 139-B, 140-E, 141-B, 142-E, 143-C, 144-A, 145-E,